УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ПАРЛАМЕНТЫН
СУДАЛГАА
ХӨГЖЛИЙН
ХҮРЭЭЛЭН

ҮГ ХЭЛЭХ, ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, МЭДЭЭЛЭЛ АВАХ, ХЭВЛЭН НИЙТЛЭХ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭ БА ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Харьцуулсан судалгаа

Судалгааны код: СТ-24/216

2024.10.10

Захиалагч: Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар

Хянасан: ПСХХ-ийн Парламентын хөгжлийн хэлтсийн дарга Ц.Норовдондог (Ph.D)

Судлаачид: Г.Билгээ, Э.Дашзэгвэ, О.Нарантуяа, Д.Жигваагүнсэл, Ц.Ариунаа, П.Уранчимэг, Б.Мөнгөнсувд, Э.Билгүүн

УЛААНБААТАР
2024 ОН

АГУУЛГА

УДИРТГАЛ 3

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ 4

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ 7

НЭГ. ҮГ ХЭЛЭХ, ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, МЭДЭЭЛЭЛ АВАХ, ХЭВЛЭН НИЙТЛЭХ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ МЕХАНИЗМ 7

1.1.Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхтэй холбоотой олон улсын хэм хэмжээ 7

1.2.Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийг хангах олон улсын механизм 8

1.3.Хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй холбоотой олон улсын хэм хэмжээ, чиг хандлага 10

1.4.Сэтгүүлчийн эрх, үйл ажиллагаа, хариуцлагатай холбоотой олон улсын хэм хэмжээ 12

ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ 15

2.1.Бүгд Найрамдах Солонгос Улс 15

2.2.Бүгд Найрамдах Энэтхэг Улс 21

2.3.Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс 26

2.4.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс 32

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ 36

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатарын захиалгаар “Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөний талаарх олон улсын хэм хэмжээ ба гадаадын зарим орны туршлага” сэдэвт харьцуулсан судалгааг Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн (ПСХХ)-д гүйцэтгэв.

Судалгааны захиалгын даалгавар:

- Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийн талаарх олон улсын хэм хэмжээ, түүний хэрэгжилтийг хангах субъектүүд;
- хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй холбоотой олон улсын хэм хэмжээ;
- сэтгүүлчийн зарим үйл ажиллагаатай холбоотой олон улсын хэм хэмжээ болон гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт (эрүүгийн болон холбогдох бусад хууль тогтоомж).

Судалгааны зорилго:

Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөний талаарх олон улсын хэм хэмжээ, түүний хэрэгжилтийг хангах субъектүүд, мөн сэтгүүлчийн зарим үйл ажиллагаатай холбоотой олон улсын хэм хэмжээ болон гадаадын зарим улсын эрүүгийн болон бусад хууль тогтоомжийн хүрээнд судлах.

Судалгааны арга зүй:

Судалгаанд НҮБ, бусад олон улсын байгууллагаас гаргасан олон улсын хэм хэмжээ болон гадаад улсын холбогдох хууль тогтоомжийг харьцуулан судлах арга зүйг ашигласан болно.

Судалгааны хамрах хүрээ:

Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөний талаарх НҮБ, бусад олон улсын байгууллагаас гаргасан хэм хэмжээ, түүний хэрэгжилтийг хангах субъектүүд талаар судлав. Мөн гадаадын зарим орны туршлагын хүрээнд ардчилсан, өндөр хөгжилтэй дараах орнуудын эрүүгийн болон болон холбогдох бусад хууль тогтоомжийг судлав. Үүнд:

- Бүгд Найрамдах Солонгос Улс;
- Бүгд Найрамдах Энэтхэг Улс;
- Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс;
- Холбооны Бүгд Найрамдах Герман Улс.

Судалгааны бүтэц:

Энэхүү судалгаа нь бүтцийн хувьд оршил, судалгааны хураангуй болон дэлгэрэнгүй хэсгээс бүрдэнэ. Судалгааны дэлгэрэнгүй хэсэг нь хоёр бүлэгтэй бөгөөд Нэгдүгээр бүлэгт - үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөний талаарх олон улсын хэм хэмжээ, түүний хэрэгжилтийг хангах механизмын талаар, Хоёрдугаарт бүлэгт - холбогдох асуудлаарх гадаадын зарим орны эрүүгийн болон болон бусад хууль тогтоомжийн талаар судалсан болно.

Түлхүүр үг: Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөө, сэтгүүлчийн эрх, худал мэдээлэл тараах.

Key words: *Freedom of speech and expression, freedom of the press, freedom of the media, freedom of publication.*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөний талаарх олон улсын хэм хэмжээ, түүний хэрэгжилтийг хангах механизм

Иргэний болон улс төрийн эрх, түүний дотор үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл авах эрх нь хүний эрхийн олон улсын гэрээгээр хүлээн зөвшөөрөгдсөн хүний үндсэн эрх юм. Энэ нь бусдын эрх, ашиг сонирхолд харшлах үед хязгаарлагдах боловч ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай механизм юм. Энэхүү эрхтэй холбоотой ***олон улсын хэм хэмжээ*** нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг онцолсон Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948), Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966) юм. Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенц (1952), Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989) нь ч хүүхэд, эмэгтэйчүүдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулдаг. Эдгээр зарчмуудыг мөн Европ, Америк, Африк зэрэг бүс нутгийн хүний эрхийн баримт бичгүүдэд тусгасан байдаг.

Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийг ***хангах олон улсын механизм*** нь НҮБ-ын төрөлжсөн байгууллага, албан тушаалтнууд юм. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл нь гишүүн орнуудын хүний эрхийн үйл ажиллагаанд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгч, эрхийг хүндэтгэх байдлыг сайжруулах талаар зөвлөмж, техникийн туслалцаа үзүүлдэг бол НҮБ-ын Хүний эрхийн Дээд комиссар нь НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад зөвлөгөө өгч, хүний эрхийн янз бүрийн хөтөлбөрүүдийг дэмжин ажилладаг. Өөр нэг механизм бол Хүний эрхийн төлөв байдлын нэгдсэн хэлэлцүүлэг байх бөгөөд НҮБ-ын гишүүн 192 орны хүний эрхийн төлөв байдлыг 4 жил тутам дүгнэн хэлэлцдэг. Мөн НҮБ-ын тусгай илтгэгч, төлөөлөгчид ихэвчлэн засгийн газрын урилгаар тухайн улсын эрх зүйн орчин, тогтолцоо, хүний эрхийн төлөв байдлын талаар мэдээлэл авч үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгдөг.

Хэвлэн нийтлэх эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалаас эхлээд бүс нутгийн хүний эрхийн конвенцууд болон бусад баримт бичгээр мөн баталгаажуулдаг. Улс орнуудын хувьд үндэсний хууль тогтоомжийг батлан энэхүү зарчмыг хэрэгжүүлж байна. Ардчилсан улс орнуудад засгийн газрын үйл ажиллагааг хянаж, сонгогчдод мэдээлэхийн тулд хараат бус хэвлэл зайлшгүй шаардлагатай байдаг бол ардчилсан бус улс орнуудад үзэл бодлыг хязгаарлахын тулд мэдээ, мэдээлэлд цензур тогтоох, шоронд хорих арга хэрэглэх тохиолдол түгээмэл байсаар байна.

Гэвч “Freedom House”-н судалгаагаар дэлхий даяар хэвлэл мэдээллийн эрх чөлөө буурч, ардчилалд заналхийлж байна: ардчилсан болон авторитар засгийн газрууд хууль тогтоомж, улс төр, санхүүгийн дарамт шахалтаар хэвлэл мэдээллийн хэрэгслийг хянаж байна. Үүнээс үл хамааран хиймэл дагуулын телевиз, блог, олон нийтийн сүлжээ зэрэг шинэ технологиуд нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх орон зайг бий болгох боломжийг олгож байна. “Freedom House” нь хэвлэн нийтлэх эрх чөлөөг хамгаалах, хангахын тулд хууль тогтоомж, санхүү, иргэний боловсрол зэргээр дэмжихийг уриалж, худал мэдээлэлтэй тэмцэхийг уриалсан байна.

Сэтгүүлчийн эрх, үйл ажиллагаа, хариуцлагатай холбоотой олон улсын хэм хэмжээ нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл авах эрх чөлөөг хамгаалахын зэрэгцээ чөлөөтэй, хариуцлагатай, мэргэжлийн ёс зүйг сахин ажиллахад чиглэгддэг. Сэтгүүлчид, тэр дундаа чөлөөт ажилтнууд, сошиал медиа контент бүтээгчид мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхтэй. ЮНЕСКО, Олон улсын сэтгүүлчид, хил хязгааргүй сурвалжлагчдын холбоо зэрэг олон байгууллага сэтгүүлчдийн аюулгүй байдал, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах чиглэлээр ажиллаж байна. Олон улсын стандартын нэг гол чиглэл бол сэтгүүлчдийн аюулгүй орчин, ялангуяа авлига, хүний эрхийн зөрчил зэрэг эмзэг сэдвүүдийг сурвалжилж буй сэтгүүлчдэд аюулгүй орчин бүрдүүлэх явдал юм. Эдгээр хүчин чармайлтыг үл харгалзан сэтгүүлчид, ялангуяа мөргөлдөөний бүсэд ноцтой аюул заналхийлсээр байгаа бөгөөд дижитал эрин үе нь хуурамч мэдээлэл, кибер халдлага зэрэг шинэ сорилтууд бий болсоор байна.

Хэдийгээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл авах эрхийн олон улсын стандарт, хэм хэмжээнүүд болон тэдгээрийг хэрэгжүүлэх олон улсын арга механизмууд оршин байгаа боловч олон саад бэрхшээлтэй тулгарсаар байна. Өнөөдөр дэлхийн олон оронд эрх баригчид хэвлэлийн эрх чөлөөг хумьж, мэдээллийн цензур тогтоон, дээрх эрхийг хязгаарласан хууль тогтоомж баталж, хэвлэл мэдээллийн хэрэгслийг хянахыг оролдож байна.

Гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт

Судалгаанд авагдсан Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ), Бүгд Найрамдах Энэтхэг Улс (БНЭУ), Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-д ***үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийг*** Үндсэн хуулиар, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (ИБУИНХУ)-д Хүний эрхийн тухай хуулиар хамгаалсан байдаг. Мөн эдгээр улсууд нь төрийн байгууллагаас мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаажуулж, ил тод байдлыг дэмжсэн бие даасан хуультай.

“Үзэл бодлоо илэрхийлэх эрх” гэдэгт юуг улс орнууд хамруулах, ямар хэлбэрээр илэрхийлэх талаар өөрсдийн улс төр, соёлын онцлогоос хамаарч харилцан адилгүй тодорхойлдог. БНСУ-ын хувьд энэхүү эрхэд үг хэлэх, хэвлэлийн эрх чөлөөг багтаасан бол БНЭУ-ын хувьд хэвлэн нийтлэх эрх чөлөө, мэдээлэл олж авах эрх, мөн үг хэлэхгүй байх эрх, (аман) яриа төдийгүй зохиол, кино, зураг, баннераас гадна спортоор хичээллэх, төрийн далбааг мандуулах зэргийг багтаажээ. ИБУИНХУ-д иргэд үзэл бодлоо илэрхийлэхдээ олон нийтийн эсэргүүцэл жагсаал цуглаанаар, нийтлэл, ном сэтгүүлээр, телевиз, радио нэвтрүүлгээр, урлагийн бүтээлээр, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан илэрхийлж болно. ХБНГУ-ын Үндсэн хуульд хүн бүр өөрийн үзэл бодлоо үгээр, бичгээр, дүрсээр чөлөөтэй илэрхийлэх, түгээхээр хуульчилжээ.

Улс орон бүр ***үзэл бодлоо илэрхийлэхэд тодорхой хязгаарлалт*** тогтоодог. Тухайлбал, БНСУ-д Үндсэн хуулиараа цензур тогтоохыг хориглодог боловч бусдын нэр төр, эрхийг зөрчиж, нийтийн ёс суртахуун, нийгмийн ёс зүйг гутааж болохгүй, ХБНГУ-д чөлөөт ардчилсан үндсэн дэг журмыг зөрчихгүй байхыг хуульчлан хязгаарлалт тогтоосон. Мөн БНЭУ-д мөн адил улсын бүрэн бүтэн байдал, аюулгүй байдал, гүтгэх, гэмт хэрэгт өдөөн хатгах зэргээс сэргийлэх үүднээс хязгаарлалт тогтоохыг зөвшөөрдөг. ИБУИНХУ-д олон нийтийн аюулгүй байдал, эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, бусдын эрх, нэр хүндийг хамгаалах, шүүхийн эрх мэдэл, шударга байдлыг хангах гэх мэт үндэслэлээр хуулийн хүрээнд хязгаарласан байдаг.

Судалгаанд авагдсан орнуудын хувьд, ***хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчдийн үйл ажиллагаа, хариуцлагыг зохицуулах эрх зүйн орчин*** нь хэвлэн нийтлэх эрх чөлөө, сэтгүүлчийн эрх, үүрэг, ёс зүйтэй сурвалжлага бэлтгэхийг чухалчилж, эдгээр зарчмуудыг хамгаалах, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжоос гадна ёс зүйн дүрмийг баримталдаг.

Сэтгүүлч ***эх сурвалжаа хамгаалах*** нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалах нэг үндсэн нөхцөл гэдгийг гадаадын улс орнууд хүлээн зөвшөөрч, хууль тогтоомжоор баталгаажуулсан бөгөөд сэтгүүлчийн эх сурвалжийг хамгаалах хуулийн зохицуулалтыг дэлхийн 100 орчим оронд бий болгосон байна. Үүнээс 20 орчим улс Үндсэн хуулиар хамгаалсан бол 90 орчим нь хэвлэлийн тухай хууль, эрүүгийн болон иргэний хуульд тухайлсан заалтууд оруулж баталгаажуулжээ.[1] Тэдгээрийн нэг нь ХБНГУ бөгөөд тус улсын Эрүүгийн болон Иргэний процессын хуульд сэтгүүлчид мэдээллийн эх сурвалжаа зарлахаас татгалзах эрхтэй байхаар хуульчилжээ. ИБУИНХУ-ын Үндэсний сэтгүүлчдийн нэгдсэн холбооны Ёс зүйн дүрэмд зааснаар сэтгүүлч нь “ажлынхаа явцад цуглуулсан нууц мэдээлэл, материалыг өгсөн эх сурвалжийн нэр төрийг хамгаална” гэж заасан нь сэтгүүлчдийн ажилд чухал ач холбогдолтой хэвээр байна.

Судалгаанд авагдсан орнуудын ***худал мэдээлэл, гүтгэлэгтэй тэмцэхэд*** чиглэсэн бие даасан хуулиуд нь хувийн нууцад халдах, гүтгэх зэрэг бусдын эрхийг зөрчсөн, олон нийтийн ёс суртахуунд хор хөнөөл учруулж болзошгүй агуулга бүхий мэдээ, мэдээлэл зэргийг нийтлэх,

[1] М.Доржханд. Сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах тухай хуулийн харьцуулсан судалгааны тайлан. https://www.globeinter.org.mn/images/upld/12057323951199256477sudalgaanii%20tailan_2.pdf

түгээхийг хориглож, хэрэв нийтэлсэн, түгээсэн тохиолдолд тухайн мэдээ, мэдээллийг устгах, залруулах, нөхөн олговор олгох зэргээр хариу арга хэмжээ авахаар хуульчилсан байна. Тухайлбал, БНСУ-ын Сүлжээний тухай хууль, БНЭУ-ын Мэдээллийн технологийн тухай хууль, ИБУИНХУ-ын Цахим аюулгүй байдлын тухай хууль, Гүтгэлгийн тухай хууль, ХБНГУ-ын Берлиний Хэвлэлийн тухай хууль зэргийг дурдаж болно. Эдгээр хуулиудын дагуу хууль зөрчсөн тохиолдолд захиргааны, иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Мөн хуулийн хариуцлагыг улсуудын эрүүгийн, иргэний болон тэдгээрийн процессын хуулиудаар давхар зохицуулдаг.

Судалгаанд авагдсан орнуудад ***сэтгүүл зүйн бие даасан байгууллагууд*** байгуулж, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, сэтгүүлчийн ёс зүйг дээдлэх, хариуцлага, сэтгүүлзүйн стандартыг сахин биелүүлэх, хэвлэл мэдээллийн байгууллагуудын эсрэг гаргасан гомдлыг шийдвэрлэх, эрх баригчдад зөвлөмж өгөх субъектүүдийг байгуулсан байна. Тухайлбал,

БНСУ-ын Хэвлэлийн арбитрын хороо нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан маргааныг шүүхийн бус аргаар хянан шийдвэрлэдэг бие даасан байгууллага юм. Тус хороо нь Хэвлэлийн арбитр, хохирол нөхөн төлөх тухай хуулийн дагуу худал мэдээлэлтэй холбоотой зөрчлийг шийдвэрлэх, эвлэрүүлэн зуучлах, хохирлыг барагдуулах зэрэг үндсэн чиг үүрэгтэй. Мөн тус улсын Гүтгэлгийн маргааныг хянан шийдвэрлэх хороо нь Сүлжээний тухай хуулийн дагуу бусдын эрхийг зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлэдэг.

Энэтхэгийн Хэвлэлийн зөвлөл нь Хэвлэлийн зөвлөлийн тухай хуулийн дагуу хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, түүний стандартыг баримтлах, боловсронгуй болгох, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ёс зүйн зөрчлийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, эрх чөлөөг хамгаалах, хангах талаар эрх баригчдад зөвлөмж өгөх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг.

ИБУИНХУ-ын Сэтгүүлчдийн аюулгүй байдлын үндэсний хороо нь сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах үүднээс сэтгүүлчдээс гадна Засгийн газар, цагдаа, иргэний нийгмийн төлөөлөл зэрэг өргөн хүрээний оролцогч талуудаас бүрддэг. Тус хорооноос "Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийг боловсруулан түүний хэрэгжилтэд хяналт тавьдаг. Энэхүү төлөвлөгөө нь аюул заналхийллийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, сэтгүүлчдийн эсрэг гэмт хэргийн хуулийн хариуцлагыг чангатгах, тэдний хувийн аюулгүй байдлыг хангах, тэр дундаа цахим хүчирхийлэлтэй тэмцэх замаар аюулгүй ажлын орчныг бүрдүүлэх зорилготой юм. Тус улсын Хэвлэл мэдээллийн хуульчдын холбоо нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр төртэй хамтран ажилладаг, мөн олон нийтийн эрх ашгийн дуу хоолойг хаах зорилготой стратегийн зарга, маргааны үр нөлөөг бууруулахад анхаарлаа хандуулдаг.

Германы Хэвлэлийн зөвлөл нь ХБНГУ-ын хэвлэл мэдээллийн салбарын зохицуулалтыг хариуцдаг сэтгүүлч, хэвлэн нийтлэгчдийн холбоодын төлөөлөгчдөөс бүрдсэн ашгийн бус байгууллага юм. Тус зөвлөл нь сэтгүүлчдэд мэдээлэл авах боломж олгох, редакцын шударга байдлыг хамгаалах, сэтгүүлчийн ёс зүйг сахиулах, хэвлэл мэдээллийн үйл ажиллагаатай холбоотой гомдлыг шийдвэрлэх, хэвлэл мэдээллийн салбарын хариуцлагыг хангах үүднээс сэрэмжлүүлэг, зөвлөмж өгөх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГ. ҮГ ХЭЛЭХ, ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, МЭДЭЭЛЭЛ АВАХ, ХЭВЛЭН НИЙТЛЭХ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ МЕХАНИЗМ

1.1.Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхтэй холбоотой олон улсын хэм хэмжээ

Иргэний болон улс төрийн эрх, түүний дотор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл авах эрх нь ардчилсан нийгмийн тулгуур нөхцөлийг бүрдүүлдэг хүний үндсэн эрхүүдийн нэг юм. Эдгээр эрхүүдийг хүний эрхийн олон улсын суурь гэрээнүүдэд тусгаж, хэрэгжилтийг нь хангуулах олон улсын арга механизмуудыг тогтоосон байдаг. Гэсэн хэдий ч энэхүү эрх нь үнэмлэхүй буюу хүний салшгүй эрх хараахан биш тул ялангуяа бусад хүний эрх, улс, нийгмийн ашиг сонирхолтой зөрчилдсөн тохиолдолд зохих хязгаарлалт, зохицуулалт хийхийг зөвшөөрдөг байна.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл авах эрх нь Хүний эрхийн дараах суурь гэрээ болон баримт бичгүүдэд тусгалаа олсон:

- **Хүний эрхийн түгээмэл тунхаглал**[2] (1948): НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ. Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын дүрэм, бусад хэм хэмжээг зөвшөөрч, 1961 оны 10 дугаар сарын 27-ны өдөр гишүүнээр элссэн. Энэхүү тунхаглалын 19 дүгээр зүйлд “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана.” гэж, 29 дүгээр зүйлийн 2-т “Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын эрх, эрх чөлөөг эрх зүйн дагуу зөвшөөрөн хүндлэх, ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэмд байдаг хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосон зохих хязгаарлалтад л захирагдана.” хэмээн заасан байдаг.
- **Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт**[3] (1966): НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200A (XXI) тогтоолоор баталж, 1976 оны 03 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон баталж, 1976 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн. Тус баримт бичгийн 19 дүгээр зүйлд “1.Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй. 2.Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр, эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар, эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана. 3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой:

  а/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх;
  б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах.” гэж заасан байна.

[2] Universal Declaration of Human Rights (UDHR). www.ohchr.org
[3] International Covenant on Civil and Political Rights (ICCPR). www.ohchr.org

- **Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенц**[4] (1952): НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1952 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар батлсан. Тус конвенцоор эмэгтэйчүүдийн сонгох, сонгогдох эрх, төрийн алба хаших, улс төрийн үйл хэрэгт эрчүүдийн нэгэн адил аливаа хэлбэрээр тэгш, чөлөөтэй оролцох эрхийг тус тус тунхагладаг.
- **Хүүхдийн эрхийн тухай конвенц**[5] (1989): Тус конвенцод хүүхдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл авах эрхийг чухалчлан тусгасан байдаг. Конвенцын 13 дугаар зүйлд хүүхдэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг олгосон бол 17 дугаар зүйлд хүүхэд үндэсний болон олон улсын янз бүрийн эх сурвалжаас мэдээлэл, материалыг олж авах боломжийг хангахад хэвлэл мэдээллийн үүрэг чухал үүрэгтэй болохыг заасан бөгөөд Хүүхдийн хөгжил, нийгмийн оролцоонд мэдээлэл чухал үүрэг онцолсон.

Мөн бүс нутгийн хэмжээний Хүний эрхийн баримт бичгүүдэд дараах баримт бичиг хамаарч байна:

- Хүний эрхийн тухай Европын конвенц, 1950 (European Convention on Human Rights, ECHR);
- Америкийн Хүний эрхийн тухай конвенц, 1969 (American Convention on Human Rights, ACHR);
- Африкийн хүний болон ард түмний эрхийн тухай дүрэм, 1979 (African Charter on Human and Peoples' Rights, ACHPR).

1.2.Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийг хангах олон улсын механизм

Хүний бусад эрхийн нэгэн адил үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл авах эрхийг дараах олон улсын арга механизмуудаар хангадаг.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл

Хүний эрхийн зөвлөл (ХЭЗ) нь дэлхий дахинаа хүний эрхийг дээдлэх, хамгаалах, хүний эрхийг хангах асуудлыг хэлэлцэж, энэ зорилтоо хэрэгжүүлэхэд чиглэсэн шийдвэр, зөвлөмж баталдаг. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2006 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 60/251 тоот тогтоолоор[6] “НҮБ-ын Хүний эрхийн комисс”-ыг “Хүний эрхийн зөвлөл” болгон НҮБ-ын гишүүн 47 улсын бүрэлдэхүүнтэйгээр өөрчлөн байгуулж, “гишүүн бүх улсынхаа хүний эрхийн үүрэг, амлалтынх нь биелэлтийн талаар үнэн бодит мэдээлэлд үндэслэн, тэдэнд шударга бөгөөд бүхий л хүрээний асуудлыг хамруулан дүгнэлт хэлэлцүүлэг хийх” дараах эрхийг олгосон:

1) дэлхийн бүх улсыг хамарсан Хүний эрхийн төлөв байдлын ээлжит хэлэлцүүлэг (Universal Periodic Review-UPR)-ийн хүрээнд НҮБ-ын гишүүн улс бүрийн хүний эрхийн байдлыг хянан хэлэлцэж, үнэлгээ, дүгнэлт өгөхийн зэрэгцээ, цаашид анхаарах асуудлаар зөвлөмж өгөх;
2) хүний эрхийн зөрчлийг олон улсын хамтын нийгэмлэгийн анхааралд хүргэж, түүнийг шийдвэрлэх арга хэмжээ авах;
3) хүний эрхийг хамгаалах гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх талаарх гишүүн орнуудын чадавхыг бэхжүүлэх, техникийн туслалцаа үзүүлэх;
4) хүний эрхийн асуудлаарх олон улсын эрх зүйг боловсронгуй болгох чиглэлээр НҮБ-ын Ерөнхий Ассамблейд зөвлөмж танилцуулах зэрэг болно.

[4] Convention on the Political Rights of Women. https://treaties.un.org
[5] Convention on the Rights of the Child (CRC). www.ohchr.org
[6] www.ohchr.org/en/hr-bodies/upr/basic-facts

ХЭЗ нь ажлаа Ерөнхий Ассамблейд тайлагнадаг. ХЭЗ нь жил бүрийн 03 дугаар сар (4 дэх долоо хоног), 06 дугаар сар (3 дахь долоо хоног), мөн 9 дүгээр сард (3 дахь долоо хоног) Швейцарын Женев хотноо хуралддаг байна.

Хүний эрхийн Дээд комиссар

Хүний эрхийн Дээд комиссар (High Commissioner for Human Rights (OHCHR)) бол НҮБ-ын хүний эрхийн гол албан тушаалтан юм. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссар нь Ерөнхий нарийн бичгийн даргын өмнө ажлаа шууд хариуцан тайлагнадаг бөгөөд Хүний эрхийн дээд комиссарын газрын бүхий үйл ажиллагааг эрхлэн хөтөлж, өдөр тутмын удирдлагаар хангадаг байна. Хүний эрхийн Дээд комиссар нь:

- НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1993 оны 48/141 дүгээр тогтоол болон бодлого боловсруулагч байгууллагын тогтоол шийдвэрээр тусгайлан даалгасан чиг үүргийг хэрэгжүүлэх;
- хүний эрхийн чиглэлээр НҮБ-аас баримталж буй бодлогын талаар НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад зөвлөгөө өгөх;
- хүний эрхийн хөтөлбөр, төсөл, үйл ажиллагаа, байгууллага, байгууллагуудад дэмжлэг үзүүлэхийг баталгаажуулах;
- хүний эрхийн байгууллагуудын хурал болон хүний эрхийн бусад арга хэмжээнд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргыг төлөөлөх болон Ерөнхий нарийн бичгийн даргын шийдвэрээр тусгай үүрэг гүйцэтгэх зэрэг болно.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1993 оны 48/141 тоот тогтоолын дагуу НҮБ-ын Хүний эрхийн Дээд комиссарыг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга газарзүйн ротацийг харгалзан 4 жилийн хугацаатай томилж, Ерөнхий Ассамблейд танилцуулдаг бөгөөд тус албан тушаалтны бүрэн эрхийг нэг удаа дахин 4 жилийн хугацаатайгаар сунгаж болно.

Хүний эрхийн хороо

Хүний эрхийн тухай суурь 9 гэрээ, тэдгээрийн нэмэлт протоколын хэрэгжилтийг хангах бие даасан шинжээчдээс бүрдсэн Хүний эрхийн суурь гэрээний байгууллагууд байдаг.[7] Тэдгээрийн нэг нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад оролцогч улсуудын хэрэгжилтэд хяналт тавьдаг бие даасан шинжээчдийн байгууллага болох Хүний эрхийн хороо юм.[8]

Хүний эрхийн хороо нь чиг үүргийнхээ хүрээнд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл авах эрхийн хэрэгжилтийг хариуцдаг байна. Энэ мэтчилэн хүний эрхийн суурь гэрээний бусад байгууллагууд нь өөр өөрийн эрхэлсэн хүний эрхийн асуудлын хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг. Жишээлбэл: Хүүхдийн эрхийн хороо нь оролцогч улс орнууддаа Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтэд хяналт тавьдаг бие даасан 18 шинжээчээс бүрдсэн байгууллага бөгөөд энэхүү байгууллага тус конвенцын нэмэлт протоколууд, хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд татан оролцуулах, хүүхэд худалдах, хүүхдийг биеэ үнэлэлт, садар самуунд татан оролцуулах зэрэгт хяналт тавьдаг ажээ.

Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг

Хүний эрхийн зөвлөлөөс 2007 оны 06 дугаар сарын 18-ны өдөр батлсан, тус зөвлөлийн гүйцэтгэх ажил үүргийг тодорхойлсон зохион байгуулалтын баримт бичиг[9] (А/ХЭЗ/шийдвэр/5/1)-ийн нэг үндсэн хэсэг нь Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн тухай байсан.

[7] www.ohchr.org/en/core-international-human-rights-instruments-and-their-monitoring-bodies
[8] www.ohchr.org/en/treaty-bodies/ccpr
[9] https://upr-mongolia.mn/images/xupld/51mon.pdf

Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (Universal Periodic Review, UPR) нь НҮБ-ын гишүүн 192 орны хүний эрхийн төлөв байдлыг 4 жил тутам дүгнэн хэлэлцэх механизм юм.

Нэгдсэн хэлэлцүүлэг нь бүх улс оронд ялгаваргүй, тэгш хандах, хэлэлцүүлэгт орж байгаа улстай хамтран ажиллах зарчимд үндэслэдэг ба улс орнууд дахь хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах, хүний эрхийг хангахад тулгарч буй бэрхшээлүүдийг даван туулахад төр засгуудад туслах, техник арга зүйн туслалцааны асуудлыг ч мөн авч үздэг онцлогтой.

Нэгдсэн хэлэлцүүлгийн зорилго нь дэлхийн бүх хүний тусын тулд улс орнуудын хүний эрхийн нөхцөл байдлыг газар дээр нь сайжруулахад оршино. Энэ зорилгодоо хүрэхийн тулд улс орнууд дахь хүний эрхийн төлөв байдлыг үнэлэх, хүний эрх зөрчигдөх тохиолдол бүрд анхаарлаа хандуулах боломжийг эрэлхийлэх бөгөөд улс орнуудад техникийн туслалцаа үзүүлэх, хүний эрхийн салбар дахь сайн туршлагаа хуваалцах, бие биесээсээ суралцах боломжийг олгох, хүний эрхийн асуудлаа хамгийн нааштайгаар шийдвэрлэх чадавхыг бэхжүүлдэг байна.

НҮБ-ын тусгай илтгэгч, төлөөлөгч

Тусгай илтгэгч, төлөөлөгчийн тогтолцоо нь НҮБ-ын хүний эрхийн механизмын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Эдгээр илтгэгч, төлөөлөгч нар нь хүний эрхийн талаар сэдэвчилсэн мэдээлэл хийх, улс орны онцлогийг таньж мэдэх, зөвлөгөө өгөх эрх бүхий хараат бус, бие даасан хүний эрхийн шинжээчид юм. Тэд НҮБ-ын ажилтан биш бөгөөд санхүүгийн урамшуулал авдаггүй. Тэднийг 3 жилээр сонгодог бөгөөд дахин 3 жилээр сунгаж болно.[10]

НҮБ-ын тусгай илтгэгч, төлөөлөгчид ихэвчлэн тухайн улсын Засгийн газрын урилгаар ирдэг бөгөөд ингэхдээ парламентын дарга, гишүүд зэрэг холбогдох байгууллага, албан тушаалтнуудтай уулзаж, эрх зүйн орчин, тогтолцоо, хүний эрхийн төлөв байдлын талаар мэдээлэл авч үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгдөг.

1.3.Хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй холбоотой олон улсын хэм хэмжээ, чиг хандлага

Хэвлэн нийтлэх эрх чөлөө нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн илрэн гарч буй нэг хэлбэр бөгөөд гол хэрэглүүр нь гэж үзэж болно. Хэвлэн нийтлэх эрх чөлөө нь иргэний эдлэх эрхээс гадна сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд илүүтэй хамаардаг ойлголт юм.[11] Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт "…үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй" хэмээн бататган хуульчилсан.

Дэлхийн улс орнууд хэвлэн нийтлэх эрх чөлөөг үндэснийхээ хууль тогтоомжоороо баталгаажуулдаг. Хамгийн анх 1766 онд Швед Улс хэвлэлийн эрх чөлөөний талаар Үндсэн хуульдаа тусгаж байжээ.[12] 1789 онд АНУ-ын Үндсэн хуулийн анхны нэмэлт, өөрчлөлтөөр хэвлэлийн эрх чөлөөг хамгаалсан бол 1982 онд Канадын эрх, эрх чөлөөний дүрмээр нээлттэй шударга ёсны зарчмаар дэмжигдсэн үг хэлэх эрх чөлөөг баталгаажуулжээ.

Ингэж хууль тогтоомжоор баталгаажуулахад бүхий л цаг үеийн сэтгэгчид, эрдэмтэн судлаачид өөрсдийн хувь нэмрийг оруулж ирсэн. XVII зуунд Европын орнуудад тэр дундаа ИБУИНХУ-д үг хэлэх, хэвлэлийн эрх чөлөөг хүлээн зөвшөөрсөн. Тухайлбал, Жон Милтон "Ареопагитика" (1644 он) номдоо сэтгэгчид цензурийг хамгийн бага байлгах талаар, Жон Стюарт Милл "Эрх чөлөөний тухай" (1869 он) номдоо хувь хүн бусад хүмүүст хор хөнөөл учруулахгүй л бол өөрийгөө илэрхийлэх эрхтэй хэмээн өгүүлсэн байдаг.

Орчин үед ардчилсан нийгмийн тулгуур нөхцөл болсон хүн бүрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1948 онд **Хүний эрхийн түгээмэл**

[10] www.ohchr.org/en/special-procedures-human-rights-council/special-procedures-human-rights-council
[11] Б.Пүрэвсүрэн. Монгол Улс дахь хэвлэн нийтлэх эрх чөлөөний хэрэгжилт, тулгамдсан асуудал. https://legaldata.mn/b/693
[12] Jonas Nordin. The Swedish Freedom of the Press Ordinance of 1766: Background and Significance. 2023.

тунхаглалд тунхаглаж, 1966 онд **Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт**ыг баталсан.

Түүнээс хойш хэвлэн нийтлэх эрх чөлөөг хангах, хамгаалах талаар олон улсын, бүс нутгийн болон үндэсний хэм хэмжээ, хууль тогтоомжууд батлагдан гарч, төрөлжсөн байгууллагууд байгуулагджээ. Тухайлбал, **Хүний эрхийн тухай Европын конвенц** (1950)-д олон нийтийн хэвлэл мэдээллийн талаарх Европын бодлого нь Европ дахь интеграчлалыг хурдасгах, ардчиллыг тууштай хэрэгжүүлэх, үндэсний дүр төрхийг хамгаалах, соёлын олон төрөл, олон ургалч үзлийг хөгжүүлэх үйлсийн түлхүүр мөн бөгөөд энэ бодлоготой уялдуулан аливаа хүний санаа бодлоо илэрхийлэх, мэдээлэл хайх эрх чөлөөг төрийн байгууллагын оролцоогүйгээр улсын хил хязгаараас үл хамааран баталгаажсан. Мөн конвенцын 10 дугаар зүйлд гишүүн орнууд сэтгүүлчдийг эдийн засгийн болон улс төрийн нөлөөнөөс ангид, хараат бусаар ажиллах механизмыг бүрдүүлэх ёстойг заажээ.

Америкийн Хүний эрхийн тухай конвенц (1969)-ийн 13 дугаар зүйлд “1.Хүн бүр бодол, санаагаа илэрхийлэх эрх чөлөөтэй… 3.Бодол, санаагаа илэрхийлэх эрх нь сонин хэвлэл, радио өргөн нэвтрүүлгийн давталтууд, мэдээлэл түгээхэд хэрэглэгддэг тоног төхөөрөмжид засгийн газрын болоод хувийн хяналт тавих зөрчил зэрэг шууд бус аргаар, эсхүл үзэл бодол, санааг мэдээлэх, түгээхэд саад хийх бусад аливаа аргаар хязгаарлагдах ёсгүй.” хэмээн заадаг.

НҮБ-аас 2016 онд гаргасан **“Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хамгаалах, түгээх тухай зөвлөмж”**-д засгийн газрууд хараат бус сэтгүүл зүйг хүндлэхээс гадна сэтгүүлчид, тэдгээрийн мэдээллийн эх сурвалжийг хуулийн хүрээнд хамгаалах ёстойг онцолдог.

Ардчилсан улс орнуудын хувьд, хараат бус хэвлэл нь төрийн үйл ажиллагааг хянаж, сонгогчдыг мэдээллээр хангахад тусалдаг учраас ардчиллын үйл ажиллагаанд нэн чухал байдаг. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тавих цензур, засгийн газрын хяналт нь амин чухал мэдээллийн хүртээмжид сөрөг нөлөөтэй ба энэ нь эцсийн дүндээ улс төрийн мэдлэг, иргэдийн оролцооны түвшнийг бууруулах замаар ардчиллын чанарт нөлөөлдөг гэж үздэг. Харин ардчилсан бус улс орнууд мэдээлэлд хяналт тавих, эсэргүү үзэл бодлыг дарахын тулд сэтгүүлчдийг ажил мэргэжлийн хувьд заналхийлэх, хорих тохиолдлууд гардаг байна.

Гэвч “Freedom House” төрийн бус байгууллагын судалгаагаар[13] сүүлийн 10 гаруй жилд дэлхий даяар хэвлэл мэдээллийн эрх чөлөө буурч байгаа бөгөөд энэ нь ардчилалд аюул занал учруулж байгааг онцолжээ. Ардчилсан орнуудад ч хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөлд засгийн газрын дэмжлэгтэйгээр өөрчлөх, санхүүгийн дарамт шахалт үзүүлэх, засгийн газрыг дэмжигч байгууллагуудад таатай хандах зэрэг арга замаар хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг сулруулж байна. Ардчилсан болон ардчилсан бус төр засгийн аль аль нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тавих хяналтаа нэмэгдүүлж, хууль тогтоомж, улс төр, эдийн засгийн арга хэмжээ авахаас гадна сэтгүүлчдэд дарамт үзүүлэж байна. Гэсэн хэдий ч Этиоп, Малайз, Армен, Эквадор, Гамби зэрэг зарим улс ардчиллыг хөгжүүлэхэд ахиц дэвшил гаргаж, хэвлэл мэдээллийн эрх чөлөө сайжирч байна. Эдгээр жишээнүүд нь улс төрийн шинэчлэл ба чөлөөт хэвлэл хоёрын нягт уялдаа холбоог онцолж, хэвлэл мэдээллийн эрх чөлөө ихэвчлэн хэлмэгдүүлэлтийн дараа хурдан сэргэдэг нь өмнө нь цензуртэй хэвлэлүүд илүү хараат бус болж байхад харагддаг.

Эрх чөлөө, олон ургалч үзэл, хараат бус сэтгүүл зүйг сурталчлах, эдгээр үзэл санааг агуулсан хүмүүсийг хамгаалах зорилготой “Хил хязгааргүй сэтгүүлчид” (RSF) байгууллагаас гаргадаг Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индексээс харахад, 2024 онд хэвлэлийн эрх чөлөө хамгийн өндөр байгаа 8 оронд Норвег, Дани, Швед, Нидерланд, Финланд, Эстони, Португал, Ирланд, Швейцар, Герман зэрэг улсуудыг жагсаасан байна. Харин хэвлэлийн эрх чөлөө хамгийн бага 10 оронд Эритрей, Сири, Афганистан, Хойд Солонгос, Иран, Туркменистан, Вьетнам, Бахрейн, Хятад, Мьянмар зэрэг улсуудыг жагсаасан байна. Монгол Улсын хувьд, Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индексээр 2023 онд 180 орноос 88-д жагсаж байсан бол 2024 онд 109

[13] Freedom and the Media 2019: A Downward Spiral. Freedom House. June 2019. https://freedomhouse.org

болж буурсан байна. Ийнхүү буурах болсон шалтгаан нь “1990-ээд оны эхэн үеэс Монгол Улс хэвлэл мэдээллийн эрх чөлөө, олон ургалч үзлийн зарчмуудыг ерөнхийд нь хүндэтгэдэг болсон боловч тус улсад мэдээллийн эх сурвалжийн нууцыг хамгаалах үндсэн эрх зүйн хамгаалалт байхгүй, гүтгэлгийн эсрэг хууль тогтоомж сул байгаа нь сэтгүүлчдийн эсрэг дур зоргоороо шүүхэд ханддаг бөгөөд энэ нь өөрийгөө цензурдах” гэсэн байна.[14]

Шинэ технологиуд нь уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслийг аажмаар орлож, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг өргөжүүлж байна. Тухайлбал, хиймэл дагуулын телевиз (satellite television) нь засгийн газруудад хяналт тавихад уламжлалт буюу газрын телевиз (terrestrial television)-ээс илүү хэцүү байдаг, учир нь тэд мэдээллээ эрх мэдлийн нөлөөнөөс гадуур цацах боломжийг олгодог ажээ. Блог, нийгмийн сүлжээ зэрэг платформууд, шууд дамжуулалт зэрэг нь сэтгүүлчид болон идэвхтнүүдэд цензурийг тойрон гарч, уламжлалт хэвлэлээс илүү хүртээмжтэй байдлаар мэдээ, мэдээллийг түгээх боломжтой байдаг.[15]

“Freedom House”-с гаргасан зөвлөмжид хэвлэн нийтлэх эрх чөлөөг хамгаалах, хангахын тулд хууль тогтоомж, санхүүгийн туслалцаа, хамгаалалтаар сэтгүүлчдийг дэмжих, иргэний боловсролоор олон нийтийг дэмжихийг уриалж, нийгмийн сүлжээ нь хэлмэгдүүлэлтийн үед үг хэлэх эрх чөлөөний хэрэгсэл болохын ач холбогдлыг онцолж, үг хэлэх эрх чөлөөг дарахгүйгээр худал мэдээлэлтэй тэмцэхэд тодорхой эрх зүйн зохицуулалт хийхийг уриалсан байна.

1.4.Сэтгүүлчийн эрх, үйл ажиллагаа, хариуцлагатай холбоотой олон улсын хэм хэмжээ

Сэтгүүлчдийн үйл ажиллагааны олон улсын жишиг нь тэдгээрийг чөлөөтэй, хариуцлагатай ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн байдаг. Сэтгүүлчийн үйл ажиллагаанд, хүний үндсэн эрхийн нэг болох үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл авах эрхийн хэрэгжилт, хамгаалалтын асуудал ч мөн адил бүрэн хамаарна.

Олон улсын сэтгүүлчдийн холбооны өгч буй тодорхойлолтоор “Сэтгүүлч гэж ажлын цагийнхаа дийлэнхийг сэтгүүлзүйн мэргэжлийн үйл ажиллагаанд зориулдаг, орон тооны, эсхүл чөлөөт байдлаар орлогынхоо ихэнхийг энэ ажлаас олдог хүн” гэж заажээ. 2014 оны 11 дүгээр сард ЮНЕСКО-гийн Мэдээлэл харилцааны хөгжлийн олон улсын хөтөлбөрийн Засгийн газар хоорондын 29 дүгээр чуулганаар “сэтгүүл зүйн үйл ажиллагаанд татагдан оролцдог хэвлэл мэдээллийн байгууллагын бусад ажилтан, нийгмийн сүлжээний контент туурвигч” нарыг сэтгүүлч гэх категорид хамааруулсан байна.

Мэдээллийн эрх чөлөө гэдгийг мэдээлэл ил тод, нээлттэй байх, хүн бүр мэдээллийг чөлөөтэй олж хүртэх боломж, баталгаа хангагдсан байхыг ойлгодог. Хүн бүр мэдээллийн эрх чөлөөг эдлэх эрхтэй. Энэхүү эрх чөлөөг эдлэхэд тодорхой арга, хэрэгсэл хэрэгтэй. Эдгээр арга, хэрэгсэл нь сэтгүүлчийн эрх, хариуцлага гэсэн категориор тодорхойлогдож байдаг. Аливаа мэдээлэл нь мэдээллийн харилцаанд оролцогч субьектийн тодорхой үйлдэл, үйл ажиллагаагаар дамжиж олон нийтэд хүрч, нийгмийн оюун санааны эрэлт хэрэгцээг хангаж байдаг. Энэ үйл ажиллагаа нь гурван үе шаттай байна:

- нэг дэх шат: мэдээлэл хайх (to seek information);
- хоёр дахь шат: мэдээлэл хүлээн авах (to receive information);
- гурав дахь шат: мэдээлэл түгээх (to impart information).

Мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх үе шатууд нь бие биетэйгээ нягт уялдаа холбоотой бөгөөд эдгээр үе шатуудыг дамжиж мэдээлэл олон нийтэд хүрдэг.

Сэтгүүлчийн эрхийг хамгаалах олон улсын байгууллагууд

[14] Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс. https://rsf.org/en/index
[15] Freedom and the Media 2019: A Downward Spiral. Freedom House. June 2019. https://freedomhouse.org

- **НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО, UNESCO):** Хэвлэлийн эрх чөлөөг дэмжих, сэтгүүлчдийн эрхийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг НҮБ-ын төрөлжсөн байгууллага. ЮНЕСКО нь сэтгүүлчдийн аюулгүй байдал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл авах эрхийг хамгаалдаг. Мөн сэтгүүлчидтэй холбоотой аливаа зөрчилд хяналт тавьж, сэтгүүлчийг аюулгүй ажиллахад нь туслах сургалт, зөвлөгөө бусад мэдээллээр хангадаг. ЮНЕСКО-гоос жил бүрийн тавдугаар сарын 3-нд тэмдэглэдэг “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр” нь сэтгүүлчдэд тулгарч буй сорилтуудын талаарх ойлголтыг нэмэгдүүлж, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах дэлхий нийтийн эв санааны нэгдлийг илэрхийлдэг байна.
- **Олон улсын сэтгүүлчдийн холбоо (IFJ)[16]:** 1926 онд үүсгэн байгуулагдсан, төв нь Бельги Улсын Брюссель хотод байрладаг, дэлхийн 140 гаруй орны 600,000 гаруй сэтгүүлчийг төлөөлдөг дэлхийн хамгийн том байгууллага бөгөөд дэлхий даяар сэтгүүлчдийн эрх, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, дэмжих чиглэлээр ажилладаг.
- **Хил хязгааргүй сурвалжлагчид (RSF)[17]:** 1985 онд үүсгэн байгуулагдсан, төв нь Парис хотод байрладаг, дэлхийн хэмжээнд хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах чиглэлээр ажилладаг гэдгээрээ алдартай. Сэтгүүлчдийн эсрэг үйлдэгдэж буй зөрчлийг хянаж, мэдээлдэг бөгөөд аюулд өртсөн сэтгүүлчдэд дэмжлэг үзүүлж, өмгөөлдөг.
- **Олон улсын хэвлэлийн хүрээлэн (IPI)[18]:** 1950 онд үүсгэн байгуулагдсан, төв нь Австри Улсын Вена хотод байрладаг, хэвлэлийн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах, сэтгүүл зүйн практикийг сайжруулах зорилготой редакторууд, хэвлэл мэдээллийн менежерүүд, тэргүүлэх сэтгүүлчдээс бүрдсэн дэлхийн сүлжээ юм.

Сэтгүүлчийн аюулгүй байдал

Олон улсын жишгийн үндсэн гол чиглэлийн нэг бол сэтгүүлчдийн аюулгүй байдал юм. НҮБ-аас 2012 онд “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах, тэдний эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйг таслан зогсоох асуудлаарх үйл ажиллагааны төлөвлөгөө”[19]-г хэрэгжүүлж эхэлсэн. Сэтгүүлчид хүчирхийлэл, дарамт, хавчлагад өртөхөөс айж, эмээхгүйгээр ажиллах аюулгүй орчин, нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатайг энэ төлөвлөгөөнд онцлон тусгаж, сэтгүүлчдийн эсрэг халдлагаас урьдчилан сэргийлэх, аюулын үед тэднийг хамгаалах, тэдний эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг яллах арга хэмжээ авахыг улс орнуудад уриалсан. Мөн тус төлөвлөгөөнд сэтгүүлчийн аюулгүй байдалд хяналт тавих, мэдээлэх үндэсний механизмыг хөгжүүлэхийг улс орнуудад зөвлөсөн. Гэсэн хэдий ч сэтгүүлчдэд тулгардаг аюул, занал нэн ялангуяа хямрал, мөргөлдөөнтэй бүс нутагт болон авлига, хээл хахууль, хүний эрхийн зөрчлийг сурвалжилж буй сэтгүүлчдэд учирч буй аюул, эрсдэл маш их байсаар байна. ЮНЕСКО-гийн мэдээлснээр, сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд олон зуун сэтгүүлч ажил үүргээ гүйцэтгэж яваад амь үрэгдэж, олон сэтгүүлч дарамт шахалт, шоронд хоригдож, хүчирхийлэлд өртөж байгаа ажээ.

Сэтгүүлчийн ёс зүй

Сэтгүүл зүйн мэргэжлийн ёс зүйн олон улсын зарчим, хэм хэмжээ нь тухайн мэргэжлийнхээ нэр төр, шударга байдал, итгэл үнэмшил, үүрэг, хариуцлагыг сахин хамгаалахад чиглэгдсэн үндсэн заавар, чиглэл нь юм. Эдгээр хэм хэмжээ нь сэтгүүлчдэд ёс зүй, ёс суртахууны нарийн төвөгтэй нөхцөл байдлыг даван туулахад нь тусалдаг бөгөөд тэдний ажил үүрэг нь хүний эрх, нэр төр, эрхэм чанарыг хүндэтгэхийн зэрэгцээ улс, олон нийтийн ашиг сонирхолд нийцэж байх шаардлага болдог. Олон улсын хэмжээнд ЮНЕСКО болон олон улсын сэтгүүлчдийн мэргэжлийн холбоодоос гаргасан дараах ёс зүйн үндсэн зарчим, дүрэм, журмыг мөрдөж байна:

[16] www.ifj.org
[17] https://rsf.org/en
[18] https://ipi.media
[19] www.unesco.org/en/safety-journalists/un-plan-action

- Сэтгүүлчийн үйл ажиллагаанд баримтлах зарчмуудын тунхаглал (Declaration of Principles on the Conduct of Journalists, 1954, IFJ)[20]:
- Сэтгүүлчийн ёс зүйн дэлхийн дүрэм (Global Charter of Ethics for Journalists, 2019, IFJ)[21]:
- Сэтгүүл зүйн мэргэжлийн ёс зүйн олон улсын зарчим (International Principles of Professional Ethics in Journalism, UNESCO)[22]:

Орчин үеийн дижитал шилжилт нь сэтгүүлчийн аюулгүй байдал болоод ёс зүйн шинэ, шинэ бэрхшээл, тулгамдсан асуудлуудыг бий болгосоор байна. Тухайлбал, сошиал медиа, нийгмийн сүлжээ дэх иргэний сэтгүүл зүйн хөгжил нь мэргэжлийн, эсхүл сонирхогчийн гэсэн зааг ялгааг улам бүдгэрүүлж, уламжлалт ёс зүйн хэм хэмжээ, арга хандлагыг хэрэгжүүлэхэд асар их хүндрэл учруулж байна. Түүнчлэн AI буюу хиймэл оюун ашигласан хуурамч, худал болон гуйвуулсан мэдээ, мэдээлэл, онлайн (тролл, бот) дарамт, гүтгэлэг, доромжлол, заналхийлэл, кибер халдлага зэрэг нь сэтгүүлчдийг болон олон нийтийг айлган сүрдүүлэх, төөрөгдүүлэхэд ашигладаг нийтлэг хэрэгсэл болжээ.

Хэдийгээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл авах эрхийн олон улсын стандарт, хэм хэмжээнүүд болон тэдгээрийг хэрэгжүүлэх олон улсын арга механизмууд оршин байгаа боловч дэлхий дахин олон саад бэрхшээлтэй тулгарсаар байна. Өнөөдөр дэлхийн олон оронд эрх баригчид хэвлэлийн эрх чөлөөг хумьж, мэдээллийн цензур тогтоон, дээрх эрхийг хязгаарласан хууль тогтоомж баталж, хэвлэл мэдээллийн хэрэгслийг хянахыг оролдож байна.

[20] https://research.tuni.fi/ethicnet/country/ifj-declaration-of-principles-on-the-conduct-of-journalists/
[21] www.ifj.org/who/rules-and-policy/global-charter-of-ethics-for-journalists
[22] https://research.tuni.fi/ethicnet/country/international-principles-of-professional-ethics-in-journalism/

Хоёр. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1.Бүгд Найрамдах Солонгос Улс

2.1.1.Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийн талаарх эрх зүйн зохицуулалт

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-д үзэл бодлоо илэрхийлэх эрх нь Үндсэн хуулиар хамгаалагдсан бөгөөд энд үзэл бодлоо илэрхийлэх бүх хэлбэр хамаарахыг тус улсын Үндсэн хуулийн шүүх үзсэн байна. Тиймээс “үзэл бодлоо илэрхийлэх эрх” гэдэгт үг хэлэх, хэвлэлийн эрх чөлөө аль аль нь багтаж байгаа юм.

Мэдээлэл олж авах, түгээх, хэвлэн нийтлэх болон эдгээрт тавих хяналтын талаар Үндсэн хууль болон хэвлэл мэдээллийн хууль тогтоомжуудаар зохицуулах бөгөөд энэ нь хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулан дэмжиж байгаа хэрэг юм. Үүнд дараах хуулиуд хамаарч байна:

- Үндсэн хууль[23];
- Сонины тухай хууль[24];
- Өргөн нэвтрүүлгийн тухай хууль[25];
- Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний ашиглалт, мэдээллийн хамгаалалтыг дэмжих тухай хууль (Сүлжээний тухай хууль);
- Хэвлэлийн арбитр, хохирол нөхөн төлүүлэх тухай хууль;
- Эрүүгийн хууль гэх мэт.

Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлд иргэдийн үг хэлэх, хэвлэн нийтлэх, жагсаал цуглаан зохион байгуулах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг баталгаажуулсан байдаг. Түүнчлэн Үндсэн хуульд иргэдийн үг хэлэх, хэвлэн нийтлэхэд нь цензур тавихгүй, жагсаал цуглаан зохион байгуулах, эвлэлдэн нэгдэхэд зөвшөөрөл шаардахгүй байхаар тогтоожээ. Гэхдээ үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэхдээ бусдын нэр төр, эрхийг зөрчиж, нийтийн ёс суртахуун, нийгмийн ёс зүйг гутааж болохгүй, хэрэв бусдын нэр төр, эрхийг зөрчсөн тохиолдолд түүнээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргаж болохыг Үндсэн хуульд хуульчилсан.

Сонины тухай хуулийн 3 дугаар зүйлд “1.Сонин, интернэт сонины хэвлэлийн эрх чөлөө, хараат бус байдлыг баталгаажуулна. 2.Сонин, интернэт сонин нь мэдээллийн эх сурвалжид чөлөөтэй нэвтрэх эрхтэй бөгөөд үг хэлэх эрх чөлөөний нэг хэсэг болгон цуглуулсан мэдээллээ чөлөөтэй нийтлэх эрхтэй. 3.Сонин, интернэт сонин нь хүний нэр төр, үнэт зүйл, ардчиллын үндсэн зарчмыг дээдэлнэ.” хэмээн заажээ.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 5 дугаар зүйлд өргөн нэвтрүүлгийн олон нийтийн хариуцлагын талаар зохицуулсан байна. Тухайлбал, өргөн нэвтрүүлэг нь:

- хүний нэр төр, үнэт зүйл, ардчиллын үндсэн зарчмыг хүндэтгэнэ;
- ард түмний эв нэгдэл, улс орны хөгжил, олон нийтийн санаа бодлыг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах ёстой бөгөөд бүс нутаг, анги давхарга, хүйсийн зөрчилдөөнийг дэмжихгүй;
- бусдын нэр төрийг гутаан доромжилж, эрхийг нь зөрчиж болохгүй;
- гэмт хэрэг, ёс суртахуунгүй үйлдэл, таамаглалыг өөгшүүлэхгүй;
- гэр бүлийн эрүүл амьдрал, хүүхэд залуучуудын чиг хандлагад сөргөөр нөлөөлөх аливаа садар самуун, бусармаг, хүчирхийллийг сурталчлахгүй зэрэг болно.

Мөн хуулийн 6 дугаар зүйлд өргөн нэвтрүүлгийн шударга байдал, олон нийтийн ашиг сонирхлын талаар дараах байдлаар зохицуулжээ:

- өргөн нэвтрүүлгийн мэдээ нь шударга, бодитой байна;

[23] БНСУ-ын Үндсэн хууль. https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=1
[24] БНСУ-ын Сонины тухай хууль. www.law.go.kr
[25] БНСУ-ын Өргөн нэвтрүүлгийн тухай хууль. www.law.go.kr

- өргөн нэвтрүүлгийн мэдээлэл нь нас, хүйс, ажил мэргэжил, шашин шүтлэг, итгэл үнэмшил, анги давхарга, бүс нутаг, арьсны өнгө гэх мэтээр ялгаварлан гадуурхаж болохгүй. Харин шашны номлолын нэвтрүүлгийн чиглэлээр мэргэшсэн бизнесийн оператор нь өөрийн чиглэлээр нэвтрүүлэг явуулдаг бол энэ нь хамаарахгүй;
- өргөн нэвтрүүлэг нь –
  - хүмүүсийн ёс зүй, сэтгэл санааны мэдрэмжийг хүндэтгэж, ард түмний үндсэн эрхийг хамгаалах, олон улсын сайн санааг дэмжихэд хувь нэмэр оруулна;
  - хүмүүсийн мэдэх эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалж, сурталчилна;
  - орон нутгийн тэнцвэртэй хөгжил, үндэсний соёлыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна;
  - стандарт хэлийг түгээхэд хувь нэмэр оруулж, хэлийг цэвэршүүлэхийг хичээнэ;
  - төрийн болон тодорхой бүлгийн бодлогыг сурталчлахдаа өөр өөр үзэл бодолтой бүлгүүдэд тэгш боломж олгохыг хичээх бөгөөд улс төрийн оролцогч талуудын талаар тэнцвэртэй байдлыг хангах зэрэг болно.

- Мэдээлэл авах талаар:

Төрийн албан ёсны мэдээлэл авах тухай хуулийн дагуу БНСУ-ын иргэн, байгууллага, аж ахуйн нэгж, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудаас мэдээлэл авах хүсэлт гаргах эрхтэй. Тодруулбал, төрийн байгууллагуудын албаны мэдээллийг авах хүсэлтийг БНСУ-д байнга оршин суудаг, эсхүл тус улсад эрдэм шинжилгээний ажил хийх зорилгоор түр хугацаагаар оршин сууж буй гадаадын иргэн мөн гаргах боломжтой. Гадаадын компани, аж ахуйн нэгжийн хувьд, хэрэв БНСУ-д өөрийн оффистой, эсхүл төлөөлөгчтэй бол дээрхийн адил хүсэлт гаргаж болно.

Гэвч хуульд заасан тодорхой тохиолдолд, тухайлбал, тухайн аж ахуйн нэгжид ноцтой хохирол учруулж болзошгүй, хувь хүн, эсхүл компанийн худалдааны нууцад халдсан бол мэдээлэл авах хүсэлтээс татгалзаж болох аж.

- Мэдээлэл цуглуулах, мэдээллийн эх сурвалжийг хамгаалах талаар:

Мэдээлэл цуглуулах явцад бусдын нэр хүнд, хувийн нууцад халдсан этгээдэд Хувь хүний нууцын тухай хууль, Иргэний хууль болон Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэдэг. Тухайлбал, мэдээлэл цуглуулах зорилгоор хууль зөрчсөн, гуравдагч этгээдийн яриаг нууцаар бичиж авсан, эсхүл өөр этгээдэд дээрх зөрчлийн аль нэгийг үйлдэхэд хүргэсэн аливаа этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Мөн ярилцлагад орсон этгээдийн харилцан яриаг зөвшөөрөлгүйгээр хийсэн тохиолдолд иргэний болон захиргааны хариуцлага хүлээлгэнэ. БНСУ-д ярианы агуулгаас гадна хүний дуу хоолой нь Хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу хувийн мэдээлэлд хамаардаг.

- Мэдээ, мэдээлэлд тавих хяналтын талаар:

БНСУ-ын Харилцаа, холбооны хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хүрээнд батлагдсан “Өргөн нэвтрүүлгийн стандартын тухай журам”, “Зар сурталчилгааны стандартын журам”-ын дагуу өргөн нэвтрүүлгийн дамжуулалтад хяналт тавьдаг байна.

Тус хороо нь өргөн нэвтрүүлгийн сувгаар нэвтрүүлсэн мэдээ, мэдээлэл, контентод хяналт тавьж, агуулга нь холбогдох хууль болон дээрх журамд нийцээгүй бол нэвтрүүлсэн өргөн нэвтрүүлгийн компани, нэвтрүүлэг түгээгч, эсхүл продакшн, компанид зохих арга хэмжээ авах үүрэгтэй. Тухайлбал, тус хороо нь мэдээ, мэдээлэл, контентыг хянаж үнэлээд, хэрэв бусдын нэр хүндэд халдсан, эрхийг нь зөрчсөн гэж үзвэл тухайн нэвтрүүлгийг залруулахыг шаардах, нэвтрүүлэхийг хязгаарлах, хориглох, холбогдох субъектийг торгох, эрүүгийн хариуцлагад татах эрхтэй ажээ.

Түүнчлэн тус улсад кино, дүрс бичлэгийн агуулгад урьдчилсан хяналт тавьж, үнэлгээ хийдэг. Хэвлэл мэдээллийн Үнэлгээний зөвлөл нь аливаа кино, дүрс бичлэгийн агуулгыг олон

нийтэд түгээхээс нь өмнө тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын дотоод хяналтын зөвлөлөөр үнэлүүлэхийг шаарддаг байна.

2023 оны 04 дүгээр сараас эхлэн “Өөрийгөө үнэлэх систем”-ийг нэвтрүүлснээр БНСУ-ын Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас эрх олгосон байгууллагууд цахим кино, дүрс бичлэгийг шууд үнэлэх боломжтой болжээ.

2.1.2.Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн үйл ажиллагаа, хариуцлагын талаарх эрх зүйн зохицуулалт

Сэтгүүлчийн үйл ажиллагаа, хариуцлагын талаар дараах хууль тогтоомжоор зохицуулж байна. Үүнд, хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаа, эрх үүрэг, сэтгүүлчийн ажиллах нөхцөл, хүрээ, хариуцлагын талаар зохицуулсан байдаг:

- Хэвлэлийн арбитр, хохирол нөхөн төлүүлэх тухай хуулийн[26] 4, 5, 14-17-2 дугаар зүйл;
- Сонины тухай хуулийн 4, 5 дугаар зүйл;
- Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 5, 6 дугаар зүйл;
- Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний ашиглалт, мэдээллийн хамгаалалтыг дэмжих тухай хуулийн[27] 44-2, 44-10 дугаар зүйл;
- Иргэний хуулийн[28] 750, 764 дүгээр зүйл;
- Эрүүгийн хуулийн[29] 33 дугаар бүлэг.

Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний ашиглалт, мэдээллийн хамгаалалтыг дэмжих тухай хууль (цаашид “Сүлжээний тухай хууль”)-аар дараах асуудлыг зохицуулдаг.

- Худал мэдээллийг устгах талаар (44-2 дугаар зүйл):

1) мэдээлэл, харилцаа холбооны сүлжээгээр олон нийтэд мэдээлэх зорилгоор түгээсэн мэдээлэл нь хувийн нууцад халдах, гүтгэх зэрэг бусдын эрхийг зөрчсөн бол эрх нь зөрчигдсөн этгээд тухайн мэдээллийг түгээсэн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгчид зөрчлийн талаар тайлбарлаж, мэдээллийг устгах, залруулга хийх хүсэлт гаргаж болно;
2) мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгч нь дээр дурдсаны дагуу холбогдох мэдээллийг устгах тухай хүсэлтийг хүлээн авсан бол устгах, түр арга хэмжээ авах зэрэг шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч, энэ тухай өргөдөл гаргагч болон мэдээллийг байршуулсан этгээдэд нэн даруй мэдэгдэнэ. Мөн авсан арга хэмжээний талаар хэрэглэгчдэд ойлгуулан, мэдээлэх ёстой;
3) мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгч нь дээрх хүсэлтийг шийдвэрлэхдээ эрх зөрчигдсөнийг нотолсон тохиолдолд цаг алдалгүй тухайн мэдээлэлд нэвтрэх эрхийг хаах, мэдээллийг устгах, нөхөн олговор олгох зэрэг арга хэмжээнүүдийг авна;
4) Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн ажиллуулж, удирдаж буй мэдээлэл, харилцаа холбооны сүлжээнд тархсан мэдээллийн талаар 2 дахь хэсэгт заасны дагуу шаардлагатай арга хэмжээ авсан бол түүнээс учирсан хохирлын хариуцлагыг бууруулж, чөлөөлж болно.

Хэвлэлийн арбитр, хохирол нөхөн төлөх тухай хууль нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан бусдын нэр хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, мөн энэ асуудлаар маргаан үүссэн тохиолдолд маргааныг шийдвэрлэх, эвлэрүүлэн зуучлах, арбитрын үйл ажиллагаа явуулахтай холбоотой харилцааг зохицуулдаг.

[26] https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=24492&lang=ENG
[27] www.law.go.kr
[28] БНСУ-ын Иргэний хууль. www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EB%AF%BC%EB%B2%95
[29] БНСУ-ын Эрүүгийн хууль. www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EB%B2%95

Тус хуулиар хэвлэл мэдээллийн байгууллага бүр Хяналтын зөвлөл (Ombudsman)-тэй байх бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгсэл түүнтэй холбоотой маргааныг эвлэрүүлэн зуучлах болон арбитрын журмаар шийдвэрлэх чиг үүрэг бүхий Хэвлэлийн арбитрын хороо ажиллахаар заасан.

Иргэний хуулийн 750 дугаар зүйлд хууль бус үйлдлээр бусдад санаатай болон болгоомжгүй байдлаар хохирол учруулсан этгээд хохирлыг нөхөн төлөхийг үүрэг болгосон бол 764 дүгээр зүйлд бусдын нэр төрийг гутаасан этгээд нь шүүхээс хохирогчийн хүсэлтээр учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төрийг нь сэргээх зохих арга хэмжээ авах зэргээр гүтгэлгийн хэргийг зохицуулсан байна. Хэрэв хэвлэл мэдээллийн байгууллага хууль зөрчсөн бол хохирсон тал нь учирсан эдийн засаг, сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргаж болох бөгөөд үүнийгээ нотлох шаардлагатай. Хэвлэлийн арбитр, хохирол нөхөн төлүүлэх тухай хууль (Act on press arbitration and damage remedies)-аас ялгаатай нь эдгээр нэхэмжлэлийг бие даасан сэтгүүлч, сурвалжлагчийн эсрэг гаргаж болно.

Эрүүгийн хуулийн 33 дугаар бүлэгт “Нэр төрийн эсрэг гэмт хэрэг”-т ногдуулах хариуцлагыг тогтоосон байна. Эрүүгийн хуульд зааснаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээ, мэдээллийн улмаас хохирсон, нэр хүндэд халдсан тохиолдолд уг мэдээлэл худал эсэхээс үл хамааран хэвлэн нийтлэгч болон хувь хүн, сурвалжлагчийн эсрэг эрүүгийн хэрэг үүсгэж болно. Хэрэв энэ мэдээлэл үнэн зөв, эсхүл олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн, нийгмийн сайн сайхны төлөө нийтэлсэн нь тогтоогдвол хэвлэн нийтлэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

Тус улсын Эрүүгийн хуульд ямар мэдээлэл, агуулгаар тарааснаас шалгалж, холбогдох хариуцлагыг тооцдог. Мөн Сүлжээний тухай хуульд олон нийтийн сүлжээгээр бусдын нэр төрийг гутаан доромжлох зорилгоор баримтыг олон нийтэд түгээж, гүтгэсэн болон худал мэдээлэл тарааж бусдын нэр төрийг гутаахтай холбоотой харилцааг зохицуулжээ.

Дээр дурдсан хоёр гэмт хэрэг нь баримт дэлгэн гүтгэх, худал баримт дэлгэн гүтгэх гэсэн хоёр өөр ойлголт бөгөөд өгсөн баримт үнэн эсэхээс үл хамааран нөгөө хүнийхээ нэр хүндийг гутаасан бол буруутай гэж үзнэ. Худал мэдээлэл тараасан гэмт хэрэг нь худал мэдээлэл тарааж гүтгэсэн хэрэгт буруутгагдах гэмт хэрэг юм.

Эрүүгийн хуулийн дагуу худал мэдээлэл тараасан тохиолдолд дараах ял шийтгэл ногдуулна:

- Гүтгэсэн хэрэгт хариуцлага тооцох талаар (307 дугаар зүйл):

    1) баримтыг олон нийтэд дэлгэн бусдын нэр төрийг гутаасан этгээдийг 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, эсхүл 5 сая хүртэл воноор торгоно;
    2) бусдыг илт худал баримтаар гүтгэсэн этгээдийг 5 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэнэ, эсхүл 10 жил хүртэл хугацаагаар эрхийг нь түдгэлзүүлнэ, эсхүл 10 сая хүртэл воноор торгоно.

- Хэвлэл мэдээллээр гүтгэсэн хэрэгт хариуцлага тооцох талаар (309 дүгээр зүйл):

    1) гүтгэх гэмт хэрэг (307.1-т заасан)-ийг сонин, сэтгүүл, радио, бусад хэвлэл мэдээллээр дамжуулан хүний нэр төрийг гутаан доромжлох зорилгоор гүтгэсэн бол 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, эсхүл 7 сая хүртэл воноор торгоно;
    2) гүтгэх гэмт хэрэг (307.2-т заасан)-ийг үйлдсэн этгээдийг 7 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, эсхүл 10 жил хүртэл хугацаагаар мэргэшлээрээ ажиллах эрхийг нь түдгэлзүүлнэ, эсхүл 15 сая хүртэл воноор торгоно.

    Мөн Сүлжээний тухай хуулийн 70 дугаар зүйлд

    1) мэдээлэл, харилцаа холбооны сүлжээгээр бусдын нэр төрийг гутаан доромжлох зорилгоор баримтыг олон нийтэд дэлгэн гүтгэсэн бол 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, эсхүл 30 сая хүртэл воноор торгоно;

2) тухайн хүнийг гүтгэх зорилгоор мэдээлэл, харилцаа холбооны сүлжээгээр худал баримтыг нийтэд дэлгэн гүтгэсэн бол 7 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, эсхүл 10 жил хүртэл хугацаагаар мэргэжлээрээ ажиллах эрхийг нь түдгэлзүүлнэ, эсхүл 50 сая хүртэл воноор торгоно.

Эрүүгийн хуульд заасан гүтгэлэг болон Сүлжээний тухай хуульд заасан цахим гүтгэлэг нь хүсэл зоригийн эсрэг гэмт хэрэг гэж үздэг бөгөөд энэ нь хохирогч нь ял эдлүүлэхийг хүсэхгүй байгаагаа илэрхийлсэн тохиолдолд түүний хүсэл зоригийн эсрэг яллах боломжгүй гэмт хэрэг юм. Энэ тохиолдолд хохирогчтой эвлэрлийн гэрээ байгуулсан бол хэргийг байгаагаар нь хааж болох буюу энэ нь яллагдагчаар татсан байсан ч хамаарна. Хохирогч ял шийтгүүлэх хүсэлтээсээ татгалзвал шүүх яллах дүгнэлтийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргана.

- Нас барсан хүний нэр төрд халдсан хэрэгт хариуцлага тооцох талаар (308 дугаар зүйл):

  Талийгаачийн нэр төрд халдсан этгээдийг илтэд худал баримтаар гүтгэсэн бол 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, эсхүл 5 сая хүртэл воноор торгоно.

- Хариуцлага тооцох эсэх талаар (310 дугаар зүйл):

  Гүтгэх (307.1-т заасан) үйлдэл нь үнэн бодит гэдэг нь тогтоогдсон, эсхүл зөвхөн нийтийн ашиг сонирхлын төлөө байвал ял шийтгэл ногдуулахгүй.

- Доромжилсон хэрэгт хариуцлага тооцох талаар (311 дүгээр зүйл):

  Бусдыг олон нийтийн өмнө доромжилсон этгээдийг 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, эсхүл 2 сая хүртэл воноор торгоно.

БНСУ-ын хэвлэл мэдээллийн хууль тогтоомж нь олон улсын жишигт нийцсэн боловч гүтгэлэг, хуурамч мэдээллийн хувьд 7 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэдэг хэвээр байгаа нь хэвлэл мэдээллийн байгууллагууд хувь хүн, компанийн нэр гэх мэт зарим нийтлэлд гол мэдээллийг орхигдуулахад хүргэдэг байна.

Мөн тус улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийг зөрчсөн, ялангуяа Хойд Солонгосын талаар нууц мэдээлэл тараасан хэргээр буруутгагдаж буй сэтгүүлчдэд 7 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр тус хуульд заасан байдаг.

Сэтгүүлчдийн холбооны ёс зүйн дүрэм[30]. Сэтгүүлчид хэвлэл мэдээллийн чөлөөт үйл ажиллагаагаар дамжуулан улс орны ардчиллыг хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах, ард түмнийг үндэсний хөгжилд зөв чиглүүлэхийн зэрэгцээ энх тайвнаар нэгдэж, үндэсний эв нэгдлийг сэргээхэд хувь нэмрээ оруулахыг уриалан дуудах үүрэгтэй. Үүний дагуу БНСУ-ын Сэтгүүлчдийн Нийгэмлэг нь ёс зүйн дүрэм, үйл ажиллагааны удирдамжийг гишүүдийнхээ дагаж мөрдөх зан үйлийн стандарт болгон тогтоож, дагаж мөрдөх, хэрэгжүүлэхийг тунхагласан. Тухайлбал:

1) хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах – бид эрх мэдэл, авлига зэрэг хэвлэлийн эрх чөлөөнд заналхийлж буй гадаад, дотоодын хувь хүн, бүлэглэлийн аливаа хууль бус хөндлөнгийн оролцоо, дарамт шахалтыг эрс эсэргүүцнэ;
2) шударга мэдээлэл – бид мэдээ мэдээлэхдээ үнэнийг эрхэмлэж, зөвхөн үнэн зөв мэдээллийг сонгож, бодит байдлыг чанд баримтална;
3) нэр төрөө хадгалах – мэдээллийг бэлтгэх явцад сэтгүүлчийн нэр төрийг шударга бус давуу тал олж авахын тулд ашигладаггүй бөгөөд сэтгүүлчид санал болгож буй хувийн ашиг сонирхлоос татгалзана;
4) мэдээллийг шударгаар цуглуулах – мэдээллийг бэлтгэх явцад аливаа мэдээллийг үргэлж шударгаар олж авдаг бөгөөд бүртгэл, өгөгдлийг өөрчилдөггүй;
5) мэдээллийг зөв ашиглах – үйл ажиллагааны явцад олж авсан мэдээллийг зөвхөн мэдээлэл бэлтгэх зорилгоор ашиглана;

[30] www.journalist.or.kr/news/section4.html?p_num=4

6) хувийн нууцыг хамгаалах – хувь хүний нэр хүндэд халдсан үндэслэлгүй мэдээллийг мэдээлэхгүй, мэдээллийн эх сурвалжийн нууцыг хамгаална;
7) сэтгүүлчдийг хамгаалах – сэтгүүлчдээ ямар ч үед хамгаална;
8) буруу ташаа мэдээллийг залруулах: аливаа алдаатай мэдээллүүдийг чин сэтгэлээсээ хүлээн зөвшөөрч, цаг алдалгүй засаж залруулна;
9) мөргөлдөөн, ялгаварлан гадуурхалтыг дэмжихийг хориглох – бүс нутаг, нийгмийн байдал, шашин, хүйс, бүлгүүдийн хооронд зөрчилдөөн үүсгэдэггүй, ялгаварлан гадуурхалтыг дэмждэггүй;
10) зар сурталчилгаа, борлуулалтын үйл ажиллагаанд тавих хязгаарлалт – компанийнхаа борлуулалт, сурталчилгааны асуудалтай холбогдуулан сэтгүүлчдийн нэр төрийг гутаасан аливаа үйл ажиллагааг зөвшөөрдөггүй.

2.1.3.Хэвлэл мэдээлэлтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх субъект

Хэвлэлийн арбитрын хороо нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээ, мэдээлэлтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх бие даасан байгууллага юм. Тус хороо нь Хэвлэлийн арбитр, хохирол нөхөн төлүүлэх тухай хуулийн дагуу олон нийтэд түгээж буй мэдээ, мэдээллийн үнэн зөв эсэхийг шалгахаас гадна хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээ, мэдээллийн улмаас хохирсон хохирогч тал болон хэвлэл мэдээллийн байгууллагын хоорондын маргаантай холбоотой дараах үндсэн 3 чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1) Зөрчил шийдвэрлэх: Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан худал мэдээ, мэдээллийн улмаас хохирол учирсан этгээд ийнхүү мэдээлсэн өдрөөс хойш 3 сарын дотор мэдээллийг залруулсан мэдэгдэл, тайлбар, тодруулгыг мэдээлэхийг шаардах эрхтэй;
2) Эвлэрүүлэн зуучлах: залруулсан мэдэгдлийн талаарх мэдээ, мэдээлэл болон түүнтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд хохирогч тал болон холбогдох хэвлэл мэдээллийн байгууллага нь Хэвлэлийн арбитрын хороонд эвлэрүүлэн зуучлах хүсэлт гаргаж болно. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор дуусгана. Хэрэв нэхэмжлэгчийн гомдол нь үндэслэлгүй болох нь тогтоогдвол эвлэрүүлэн зуучлах хүсэлтийг хэрэгсэхгүй болно;
3) Арбитр: Залруулсан мэдэгдлийн талаар тайлан гаргах, хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой маргааны үед хоёр тал эрх бүхий арбитрын шийдвэрийг эцсийнх байхаар тохиролцон арбитрт өргөдөл гаргаж болно. Энэ тохиолдолд арбитрын шийдвэр эцсийнх байна.

Хэвлэлийн арбитрын хороо нь 40-өөс доошгүй, 90-ээс илүүгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд нэг дарга, 2 дэд дарга, 2-оос доошгүй аудитортай байна. Хорооны бүрэлдэхүүнд хуульчид, сэтгүүл зүй, сурвалжлах чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай сэтгүүлч, сурвалжлагч болон хууль, сэтгүүл зүйн чиглэлийн багш, шүүгч, өмгөөлөгч, хэвлэл мэдээллийн ахмад, туршлагатай ажилтнууд ордог.

Бүтэц, зохион байгуулалтын хувьд, Сөүлийн тойргийн 5, орон нутаг болон том хотуудыг харьяалсан 10, нийт 15 арбитрын хороотой, мөн хорооны үйл ажиллагааг дэмжих чиг үүрэг бүхий Тамгын газартай.

Сүлжээний тухай хуулийн 44-10 дугаар зүйлд Гүтгэлгийн маргааныг хянан шийдвэрлэх хорооны талаар зохицуулсан байдаг. **Гүтгэлгийн маргааныг хянан шийдвэрлэх хороо** нь мэдээлэл, харилцаа холбооны сүлжээгээр түгээж буй мэдээллийн дунд бусдын эрхийг зөрчсөн, тухайлбал, хувийн нууцад халдах, гүтгэх зэрэгтэй холбоотой маргааныг үр дүнтэй шийдвэрлэх үүрэгтэй 5 гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн нэгээс доошгүй нь мэргэшсэн өмгөөлөгч байна.

2.2.Бүгд Найрамдах Энэтхэг Улс

2.2.1.Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийн талаарх эрх зүйн зохицуулалт

Бүгд Найрамдах Энэтхэг Улс (БНЭУ)-ыг “дэлхийн хамгийн том ардчилсан улс” хэмээн Олон улсын хамтын нийгэмлэг үнэлж ирсэн бөгөөд тус улс нь хараат бус хэвлэлийг дэмжсээр ирсэн.[31] Тус улсад иргэд бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийн талаар Үндсэн хууль, Мэдээлэл олж авах эрхийн тухай хууль болон бусад хуулиар зохицуулдаг.

Үндсэн хуулийн 19, 20, 21А, 22 дугаар зүйлд хүний эрх, нэр төртэй амьдрах эрх, эрх чөлөөг баталгаажуулсан. Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн (1)(а) хэсэгт заасны дагуу иргэн бүр үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Үг хэлэх эрх чөлөө нь амьд явах эрхтэй салшгүй холбоотой хэмээн БНЭУ-ын Дээд шүүхээс үзсэн байна. Энэхүү эрхэд хэвлэн нийтлэх эрх чөлөө, мэдээлэл олж авах эрх, мөн үг хэлэхгүй байх эрх, (аман) яриа төдийгүй зохиол, кино, зураг, баннер зэргийг багтаадаг. Түүнчлэн спортоор хичээллэх, төрийн далбааг мандуулах зэрэг нь өөрийгөө илэрхийлэх буюу үг хэлэх эрх чөлөөний нэг хэлбэр гэж Дээд шүүхээс үзжээ.[32]

Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн (2) дахь хэсэгт үг хэлэх эрх чөлөөг хязгаарласан нь улсын бүрэн бүтэн байдал, аюулгүй байдал, бүрэн эрхт байдал, гадаад улстай найрсаг харилцаа тогтоох, нийтийн хэв журмыг сахиулах, гүтгэх, гэмт хэрэгт өдөөн хатгах, шүүхийг үл хүндэтгэх зэргээр үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг төрөөс хязгаарласан байна.

Мэдээлэл олж авах эрхийн тухай хуулиар[33] тус улсын иргэд төрийн байгууллагууд, яамд, Засгийн газраас санхүүждэг бусад байгууллагуудаас мэдээлэл авах эрхийг баталгаажуулан зохицуулдаг. Тодруулбал, иргэд хуулиар хориглосон мэдээллээс бусад мэдээллийг төрийн байгууллагаас шаардах эрхтэй. Иргэд мэдээлэл авахдаа төрийн байгууллагад англи, хинди хэлээр бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хүсэлт гаргаж, бүртгэл, баримт бичиг, санамж, цахим шуудан, санал бодол, тайлан, цахим өгөгдөл гэх мэт ямар ч хэлбэрээр авах боломжтой.

Төрийн байгууллагуудын хувьд, бүх мэдээлэл, бүртгэлээ зохих журмын дагуу хөтлөх, каталогжуулах, индексжүүлэх, цахим сүлжээнд байршуулах, бусад системүүдэд холбосноор иргэдийн мэдээлэл авах эрхийг хөнгөвчлөх, богино хугацаанд авах боломжоор хангах үүргийг хүлээнэ. Мөн төрийн байгууллагууд нь мэдээлэл, бүртгэлээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах, мэдээллийн самбарт байршуулах зэргээр хялбар, хүртээмжтэй байдлаар олон нийтэд түгээх үүрэгтэй.

2.2.2.Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн үйл ажиллагаа, хариуцлагын талаарх эрх зүйн зохицуулалт

БНЭУ-д 20 гаруй хэлээр хэвлэгддэг 140,000 орчим хэвлэл байдгаас 20,000 нь өдөр тутмын сонин, хувийн хэвшлийн 900 орчим телевиз байдгаас тал хувь нь мэдээний суваг байна. Тус улсын Засгийн газар нь 23 хэлээр нэвтрүүлгээ цацдаг Doordarshan олон нийтийн телевизийг байгуулсан. Радио нь төрийн мэдэлд монопол хэвээр байгаа бөгөөд Бүх Энэтхэгийн Радио (All India Radio) нь Засгийн газрын мэдэлд байдаг. Тус улсын залуучууд нь олон нийтийн цахим мэдээллийн хэрэгслийг ихээр ашигладаг бөгөөд хэрэглээний хувьд мэдээллийн гол эх сурвалж болох хэвлэл мэдээллийн бусад хэрэгслийг гүйцэж түрүүлж байна.

Дэлхийн нийт сэтгүүлчдийн эрхийг хамгаалах, хэвлэлийн эрх чөлөөний төлөө тэмцэн ажилладаг, хараат бус, ашгийн бус байгууллага болох Сэтгүүлчдийг хамгаалах хорооны[34] судалгаагаар 1992-2024 оны хооронд БНЭУ-д 59 сэтгүүлч амь насаа алдаж, 7 сэтгүүлч хоригдсон

[31] Д.Баярхүү. Энэтхэг: Сонгуулийн соёл ба улс төрийн эрх мэдэл. Шинэ толь №23, 2000. https://academy.edu.mn
[32] https://byjus.com/free-ias-prep/freedom-of-speech/
[33] Right to Information Act, 2006. www.indiacode.nic.in/bitstream/123456789/2065/5/a2005-22.pdf
[34] Committee to Protect Journalists. https://cpj.org/data/killed/asia/india/

байна. Өөрөөр хэлбэл, жилд дунджаар 3-4 сэтгүүлч ажил үүргээсээ болж амь насаа алдаж байгаа нь тус улсын хэвлэл мэдээллийн салбар нь хамгийн аюултай улсуудын нэг хэмээн тэмдэглэжээ.

БНЭУ-ын Үндсэн хуулиар хэвлэн нийтлэх эрх чөлөөг үндсэн эрх хэмээн тунхаглаж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний салшгүй хэсэг бөгөөд ардчилсан тогтолцооны зайлшгүй нөхцөл хэмээн үздэг. Түүнчлэн хүний эрхийг дээдэлдэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь хууль тогтоомжийн хүрээнд ажиллах үүрэг хүлээдэг. Тус улсын **Үндсэн хуулийн** 19 дүгээр зүйлийн 1(а) хэсэгт тус улсын иргэдэд үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн эрхийг баталгаажуулсан. Энэ нь хувь хүн үг хэлэх, бичих, хэвлэх, харилцах гэх мэт төрөл бүрийн хэрэгслээр өөрийн үзэл бодол, итгэл үнэмшлээ чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангадаг.

Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн үйл ажиллагааны талаар Үндсэн хуулиас гадна дараах хууль тогтоомжоор зохицуулж байна:

- Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллагсдын тухай хууль[35];
- Харилцаа холбооны зохицуулах газрын тухай хууль[36];
- Кабелийн телевизийн сүлжээний тухай хууль[37];
- Хэвлэл, тогтмол хэвлэлийн бүртгэлийн тухай хууль[38];
- Мэдээллийн технологийн тухай хууль[39];
- Шударга ёсны тухай хууль[40].

Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллагсдын тухай хуулиар сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллагад ажилладаг бусад ажилтнуудын үйл ажиллагаа, үйлчилгээний нөхцөлийг зохицуулдаг. Уг хуулийн дагуу “сэтгүүлч” гэдгийг сэтгүүлч мэргэжилтэй бөгөөд нэг болон хэдэн хэдэн сонинд ажилладаг хүнийг хэлнэ гэсэн байна. Сэтгүүлч нь аль ч сонины байгууллагад (цайны цагийг эс тооцох) 4 долоо хоног дараалан 144 цагаас илүү хугацаагаар ажиллахыг шаардах эрхгүй бөгөөд зөвшөөрөх ёсгүй, долоо хоногт дараалсан 24 цагаас багагүй хугацаагаар амрах эрхтэй, Төв Засгийн газраас баталсан журмын дагуу ажил олгогчоос цалин хөлс авах эрхтэй бөгөөд ямар ч тохиолдолд журамд заасан цалин хөлсний хэмжээнээс доогуур байж болохгүй гэж тусгасан байна.

Харилцаа холбооны зохицуулах газрын тухай хуулиар харилцаа холбооны үйлчилгээ, харилцаа холбооны салбарын үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, холбогдох маргааныг хянан шийдвэрлэх, давж заалдах гомдлыг шийдвэрлэх харилцааг зохицуулдаг. Уг хуулийн дагуу харилцаа холбооны үйлчилгээг зохицуулах, үйлчилгээний тарифыг тогтоох зэрэг чиг үүрэг бүхий Харилцаа холбооны зохицуулах газрыг[41] байгуулсан. Тус газар нь мэдээллийн эрин үед тус улсын харилцаа холбооны салбарыг хурдацтай хөгжүүлж, БНЭУ-ыг тэргүүлэгч болгох явдал зорилготой ажээ.

Кабелийн телевизийн сүлжээний тухай хуулиар улсын хэмжээнд кабелийн телевизийн сүлжээний үйл ажиллагаа, түүнтэй холбоотой харилцааг зохицуулдаг. Тухайлбал, кабелийн телевизийн операторууд нь эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авч, бүртгэлийн үйл явцыг дагаж мөрдөхийг заасан байна. Кабелийн телевизээр цацагдаж буй контентын удирдамж, жишээлбэл, дороомжилсон, олон нийтийн ёс суртахуунд хор хөнөөл учруулсан, үндэсний ашиг сонирхлын эсрэг байж болзошгүй зарим төрлийн контентыг дамжуулахыг хуулиар хязгаарлаж, сурталчилгааны агуулгын стандартыг тогтоож өгсөн. Уг хуулийг дагуу кабелийн телевизийн дамжуулах стандарт, бүртгэл, техникийн шаардлага зэргийг зохицуулах журмыг Төв Засгийн газар батална.

[35] Working Journalists and other Newspaper Employees (Conditions of Service) and Miscellaneous Provisions Act, 1955. www.indiacode.nic.in/handle/123456789/1504?view_type=browse
[36] Telecom Regulatory Authority of India Act, 1997. www.indiacode.nic.in/handle/123456789/1929
[37] Cable television networks (regulation) Act, 1995. www.indiacode.nic.in/handle/123456789/1928
[38] Press and registration of periodicals act, 2023. www.indiacode.nic.in/handle/123456789/20162
[39] Information Technology Act, 2000. www.indiacode.nic.in/handle/123456789/1999
[40] Bharatiya Nyaya Sanhita, 2023. www.indiacode.nic.in/handle/123456789/20062?view_type=search&col=123456789/1362
[41] Telecom Regulatory Authority of India (TRAI). https://trai.gov.in

Хэвлэл, тогтмол хэвлэлийн бүртгэлийн тухай хуулиар тогтмол хэвлэлийн бүртгэл, бүртгэлийн гэрчилгээ, хэвлэх, хэвлэлийг зогсоох, хэвлэлийн бүртгэгч болон ажилтнуудтай холбоотой харилцааг зохицуулдаг.

Мэдээллийн технологийн тухай хуулиар цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой харилцааг зохицуулдаг. Тухайлбал, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн платформ дээр хуваалцсан, эсхүл байршуулсан контентыг хариуцах зуучлагчийн үүрэг, хариуцлагыг хуульчилсан: зуучлагч нь тодорхой шаардлагуудыг дагаж мөрдөх бөгөөд ёс суртахууны эсрэг контент, хүүхдийн порнограф, гэмт хэрэгт өдөөн турхирсан агуулгатай зэрэг хууль бус контентыг устгах, хаах эрхтэй. Энэ хуулийн дагуу бүх төрлийн цахим хэрэгслээр гүтгэсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцож, хор хохирлоос хамааран торгууль ногдуулахаас эхлээд хорих ял шийтгэл оногдуулна.

БНЭУ-ын **Шударга ёсны тухай хууль** буюу эрүүгийн хууль нь гэмт хэргийн төрөл, гэмт хэрэг үйлдсэн хүн бүрд шийтгэл оногдуулахтай холбоотой харилцааг зохицуулсан цогц хууль юм. Тус хуулиар хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн эрх, үүрэг, үйл ажиллагаа зэргийг тусгайлан зохицуулаагүй ч зарим заалтууд нь хэвлэл мэдээллийн үйл ажиллагаатай хамааралтай байна.

- Үнэн зөв мэдээлэл өгөөгүй хэрэгт хариуцлага тооцох талаар (212 дугаар зүйл):

  Хуулийн энэ зүйлийн дагуу төрийн албан хаагч нь үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй бөгөөд санаатай худал мэдээлэл өгсөн бол дараах шийтгэлийг оногдуулна[42]:

  1) 6 сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, эсхүл 5000 хүртэл рупигээр торгоно, эсхүл хоёуланг нь шийтгэнэ;
  2) гэмт хэргийг нуун дарагдуулах, гэмт этгээдийг баривчлахад саад болох зорилгоор худал мэдээлсэн 2 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ, эсхүл торгоно, эсхүл хоёуланг нь шийтгэнэ.

- Гүтгэсэн хэрэгт хариуцлага тооцох талаар (356 дугаар зүйл):

  Хуулийн энэ зүйлийн дагуу аливаа этгээдэд гэм хор учруулах зорилгоор үг хэлээр, нийтлэлээр, эсхүл дохио, харагдахуйц дүрслэлээр дамжуулан гүтгэсэн, эсхүл ийм доромжлол нь тухайн хүний нэр хүндэд гэм хор учруулна гэдгийг мэдсээр байж зориуд санаатай хийсэн үйлдлийг хэлэх бөгөөд дараах шийтгэлийг оногдуулна:

  1) хэн нэгнийг гүтгэсэн бол 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, эсхүл торгоно, эсхүл дээрх хоёуланг нь шийтгэнэ, эсхүл нийтэд тустай ажил хийлгэнэ;
  2) хэн нэгний нэр төрийг гутаан доромжилно гэдгийг мэдсээр байж, эсхүл ийм үйлдэл болох хангалттай үндэслэлтэй байхад тухайн мэдээллийг хэвлэн нийтэлсэн бол 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, эсхүл торгоно, эсхүл хоёуланг нь шийтгэнэ;
  3) гүтгэлгийн шинж чанартай аливаа мэдээллийг мэдсээр байж зарсан, худалдахаар санал болгосон бол 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, эсхүл торгоно, эсхүл хоёуланг нь шийтгэнэ.

- Гутаасан, доромжилсон хэрэгт хариуцлага тооцох талаар (XVII бүлэг):

  1) Иргэдийн шашин шүтлэг, итгэл үнэмшлийг гутаах зорилготой санаатай, хорон үйлдэл (299 дүгээр зүйл) – Тус улсын аль ч иргэдийн шашин шүтлэг, итгэл үнэмшлийн талаар доромжилсон санаатай, хорлонтой үг хэллэг, бичиглэл, тэмдэг, харагдахуйц дүрслэл, цахим болон бусад хэрэгслээр доромжлох, доромжлохыг оролдсон хүнийг 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, эсхүл торгоно, эсхүл хоёуланг нь шийтгэнэ;
  2) Аливаа хүний шашны шүтлэгийг сэвтүүлэх зорилгоор үг хэлэх (302 дугаар зүйл) – Хэн ч байсан зориудаар аливаа хүний шашин шүтлэгийг доромжлох, санаатайгаар тухайн хүнд

[42] www.indiacode.nic.in/handle/123456789/20062?view_type=search&col=123456789/1362

сонсогдохоор ямар нэгэн үг хэлэх, дуу авиа гаргах, түүний нүдэн дээр ямар нэгэн дохио зангаа хийсэн, түүнд харагдахаар ямар нэгэн зүйл тавьсан бол 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, эсхүл торгоно, эсхүл хоёулангаар нь шийтгэнэ;

3) Амгалан тайван байдал алдагдуудах зорилгоор санаатайгаар доромжлох (352 дугаар зүйл) – Хэн нэгэн хүнийг санаатайгаар доромжилж, өдөөн хатгасан нь олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах, өөр гэмт хэрэг үйлдэхэд хүргэж болзошгүйг мэдсээр байж хэн нэгнийг өдөөн хатгасан бол 2 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ, эсхүл торгоно, эсхүл хоёулангаар нь шийтгэнэ.

2.2.3.Хэвлэн нийтлэх эрх чөлөө, сэтгүүлчийн эрхийг хамгаалах субъект

Энэтхэгийн хэвлэлийн зөвлөлийг Хэвлэлийн анхны комиссын зөвлөмжийн дагуу 1966 онд байгуулжээ.[43] Тус зөвлөл нь хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, түүний стандартыг баримтлах, боловсронгуй болгох, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ёс зүйн зөрчлийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, эрх чөлөөг хамгаалах, хангах талаар эрх баригчдад зөвлөмж өгөх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Хэвлэлийн зөвлөлийн тухай хууль , түүнтэй холбоотой дүрэм журмыг баримтлан ажилладаг.

Энэтхэгийн хэвлэлийн зөвлөлийг Төв Засгийн газраас томилох бөгөөд албан ёсны төрийн хэвлэлд нийтэлснээр байгуулагдсанд тооцно. Зөвлөл нь шүүхэд нэхэмжлэл гаргах эрх бүхий байгууллага (корпорац) бөгөөд байнгын, тасралтгүй үйл ажиллагаа явуулна.

Энэтхэгийн хэвлэлийн зөвлөлийн зорилго нь хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, тус улсын сонин, мэдээллийн агентлагийн баримтлах стандартыг мөрдүүлэх, сайжруулахад чиглэгдэх бөгөөд энэхүү зорилгодоо хүрэхийн тулд дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана:

- сонин, мэдээллийн агентлагуудад бие даасан байдлаа хадгалахад туслах;
- сонин, мэдээллийн агентлаг, сэтгүүлчдийн ёс зүйн дүрмийг мэргэжлийн өндөр түвшин, стандартад нийцүүлэх;
- сонин, мэдээллийн агентлаг, сэтгүүлчид иргэний эрх, үүргийн талаар зохих ёсны ойлголтыг төлөвшүүлэх;
- сэтгүүлч мэргэжлээр ажилладаг бүх хүмүүсийн үүрэг хариуцлага, төрийн үйлчилгээний мэдрэмжийг нэмэгдүүлэх;
- нийтийн эрх ашигтай холбоотой мэдээний нийлүүлэлт, түгээлтийг хязгаарлаж болзошгүй аливаа үйлдлийг хянах;
- тус улсын сонин, мэдээллийн агентлагаас гадаадын ямар нэг эх сурвалжаас авсан тусламж, түүний дотор Төв Засгийн газраас тухайн байгууллагад шилжүүлсэн, эсхүл хувь хүн, холбоо, аль нэг этгээдээс өгсөн хандив, тусламжийг хянах;
- гадаадын улсад бүртгэлтэй сонин, түүний дотор гадаад улсаас БНЭУ-д суугаа Элчин сайдын яам болон бусад төлөөлөгчийн газраас гаргасан сонин, хэвлэл, тэдгээрийн тархалт, нөлөөллийн талаарх судалгааг хийх;
- сонин, хэвлэл мэдээллийн агентлагт үйл ажиллагаа эрхэлдэг бүх ангиллын хүмүүсийн хоорондын үйл ажиллагааны харилцааг дэмжих;
- хэвлэлийн хараат бус байдалд нөлөөлж болзошгүй сонин, мэдээллийн агентлагуудын төвлөрөл, өмчлөлийн асуудал зэрэгт анхаарал хандуулах;
- Төв Засгийн газраас шилжүүлж ирүүлсэн аливаа асуудлын талаар санал бодлоо илэрхийлэх;
- дээрх чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой бусад чиг үүргийг гүйцэтгэх зэрэг болно.

Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Хэвлэлийн зөвлөлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд зохицуулсан байна. Зөвлөл нь дарга, 28 гишүүнээс бүрдэнэ. Даргыг тус улсын Парламентын дээд танхим болох Төрийн зөвлөл (Rajya Sabha)-ийн дарга, доод танхим болох Ардын танхим (Lok Sabha)-ын

[43] Press Council of India. www.presscouncil.nic.in/ResumeOfPCI.aspx

дарга болон Зөвлөлийн гишүүдээс сонгогдож бүрдсэн хорооноос[44] нэр дэвшүүлж, Төв Засгийн газар томилдог. Бусад гишүүдийг тогтоосон журмын дагуу дараах байдлаар бүрдүүлнэ:

- мэргэжлээрээ ажиллаж байгаа сэтгүүлчдээс 13 хүнийг нэр дэвшүүлэх бөгөөд тэдгээрийн 6 нь сонины эрхлэгч, 7 нь редактор бус сэтгүүлчид байна;
- сонины эзэмшигч, эздээс 6 хүнийг нэр дэвшүүлэх бөгөөд сонины том, дунд, жижиг ангилал[45] тус бүрээс 2 төлөөлөгч байна;
- мэдээллийн агентлагуудын удирдлагаас нэр дэвшүүлнэ;
- гишүүдийн 3 нь боловсрол, шинжлэх ухаан, хууль, утга зохиол, соёлын мэргэшилтэй байна. Их сургуулийн тэтгэлэг олгох комиссоос 1, Энэтхэгийн Хуульчдын зөвлөлөөс 1, Саитияа академиас (Sahitya Academy) 1 хүнийг тус тус нэр дэвшүүлнэ;
- гишүүдийн 5 нь Парламентын гишүүн байх бөгөөд тэдний 3-ыг нь Ардын танхимын дарга гишүүдийнхээ дундаас, 2-ыг нь Төрийн зөвлөлийн дарга гишүүдийнхээ дундаас тус тус нэр дэвшүүлнэ.

Энэтхэгийн сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл[46] нь тус улсын төрийн сэтгүүлчдийн эвлэл, холбоодоос бүрдэх бөгөөд нийт сэтгүүлчдийн тэргүүлэх байгууллага гэж тодорхойлжээ. 1990 онд байгуулагдсан тус эвлэлийн зорилго нь хэвлэл мэдээллийнхэнд тулгарч буй, өсөн нэмэгдэж буй сорилтуудыг даван туулахад туслах, эрх чөлөөтэй, ил тод, айдасгүйгээр дөрөв дэх засаглалын эрх мэдлийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ. Мөн сэтгүүлчийн эрх, хувийн аюулгүй байдлыг хамгаалахын зэрэгцээ иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах, хүний эрхийг хамгаалж, хөгжиж буй ардчилсан нийгэмд чухал ач холбогдолтой нийгмийн шударга ёсны төлөө тэмцэнэ гэжээ. Эвлэл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- мэргэжлийн сэтгүүлч гишүүдийн статусыг дээшлүүлэх;
- сэтгүүлчдийн хамтын ажиллагаа, ойлголцлыг дэмжих;
- мэргэжлийн ёс зүй, шударга байдлын стандартыг мөрдүүлэх, сурталчлах, хамгаалах;
- сэтгүүлчдийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангуулах, ялангуяа цалин хөлс, ажлын байр, үйлчилгээний нөхцөлийг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх;
- аливаа хууль зүйн туслалцаа үзүүлэх (ажилгүйдэл, тэтгэвэрт гарах, нас барах зэрэг аливаа тусламж дэмжлэг хэрэгтэй үед);
- хэвлэлийн эрх чөлөөний төлөө тэмцэх;
- ажиллаж буй сэтгүүлчийн сайн сайхны төлөө хууль батлуулахад анхаарах;
- бусад чиг үүргүүдийг хэрэгжүүлдэг байна.

Энэтхэгийн үндэсний сэтгүүлчдийн эвлэлийг[47] 1972 онд олон нийтэд нэр хүндтэй, шилдэг сэтгүүлчид үүсгэн байгуулсан бөгөөд хэвлэл мэдээллийн ажилтнуудын эрх ашгийг хамгаалан ажилладаг үндэсний байгууллага юм. Тус эвлэлийн зорилго нь сэтгүүл зүйн салбарт өндөр стандарт тогтоох, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эрх ашгийг хамгаалах, эрх зөрчигдсөн бол тэдний дуу хоолой болох бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- сэтгүүлчдийн мэргэжлийн ур чадвар, ашиг сонирхол, статусыг сурталчлах, хамгаалах;
- мэргэжлийн ёс зүй, шударга байдлын хамгийн дээд стандартыг сурталчлах, хамгаалах;
- хэвлэлийн эрх чөлөө, бие даасан байдлын төлөө тэмцэх, хамгаалах;
- сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалах, дэмжих, шаардлагатай тохиолдолд гишүүдийг ажлын байраар хангахад нь туслах;

[44] www.indiacode.nic.in/show-data?abv=CEN&statehandle=123456789/1362&actid=AC_CEN_29_41_00008_197837_1517807325006&sectionId=9080&sectionno=8&orderno=8&orgactid=AC_CEN_29_41_00008_197837_1517807325006

[45] Хуулийн тайлбар хэсэгт сонинг хэвлэгдсэн тооноос нь хамаарч том, дунд, жижиг гэж Төв Засгийн газраас мэдэгддэг ба албан ёсны хэвлэлд нийтэлдэг байна. www.indiacode.nic.in/show-data?abv=CEN&statehandle=123456789/1362&actid=AC_CEN_29_41_00008_197837_1517807325006&sectionId=9077&sectionno=5&orderno=5&orgactid=AC_CEN_29_41_00008_197837_1517807325006

[46] Indian Journalists' Union (IJU). https://iju.org.in

[47] National Union of Journalist India (NUJ-I). www.nujindia.com

- сэтгүүлчдийн ажиллах нөхцөлийг сайжруулах, ялангуяа цалин хөлс, албан тушаал хаших нөхцөл, нэмэгдэл, хангамж, эрх ямбатай холбоотой асуудлыг айдасгүйгээр, хэнээс ч үл хамааран сайжруулахыг эрмэлзэх;
- хэвлэлийн эрх чөлөө, хараат бус байдал, хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалт, сонины салбарыг хөндлөнгийн нөлөөллөөс ангид зөв хөгжүүлэхийн тулд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах;
- сэтгүүлчдийг давтан сургах, тэдний ажлын чанарыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;
- хэвлэлтэй холбоотой статистик болон бусад мэдээллийг цуглуулах, ангилах, түгээх, чөлөөт хэвлэлийг хөгжүүлэх;
- сэтгүүлчдийн хоршоодыг дэмжих, сурталчлах, хөрөнгө оруулалт хийх, сонин, мэдээллийн агентлаг, цахим мэдээллийн сувгийг шинээр нээх;
- Эвлэлийн дүрэмд заасан бусад чиг үүрэг.

2.3.Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс

2.3.1.Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийн талаарх эрх зүйн зохицуулалт

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (ИБУИНХУ)-д үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийг зохицуулсан үндсэн барит бичиг бол **Хүний эрхийн тухай хууль**[48] юм. Энэ хуулийн 10 дугаар зүйлд хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй бөгөөд энэ нь төрийн эрх мэдлээр хязгаарлагдахгүйгээр үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хүлээн авах, түгээх эрхийг багтаадаг. Иргэд үзэл бодлоо олон нийтийн эсэргүүцэл жагсаал цуглаанаар, нийтлэл, ном сэтгүүлээр, телевиз, радио нэвтрүүлгээр, урлагийн бүтээлээр, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан илэрхийлж болно.

Гэхдээ энэхүү эрх чөлөө нь олон нийтийн аюулгүй байдал, эмх замбараагүй байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, бусдын эрх, нэр хүндийг хамгаалах, нууцаар хүлээн авсан мэдээллийг задруулахаас урьдчилан сэргийлэх, эсхүл шүүхийн эрх мэдэл, шударга байдлыг хадгалах зорилгоор дараах хуулийн хүрээнд хязгаарлаж, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцно:

- **Ёс суртахууны эсрэг харилцааны тухай хууль** (Malicious Communications Act) болон **Харилцаа холбооны тухай хуулиар** зохисгүй харилцаа, доромжлол, заналхийлэлтэй холбоотой асуудлыг;
- **Нийтийн хэв журам сахиулах тухай хуулиар** Арьс өнгө, шашин шүтлэг, бэлгийн чиг хандлагаар нь ялгаварлан гадуурхахтай холбоотой асуудлыг;
- **Терроризмын тухай хуулиар** Терроризмыг өөгшүүлсэн гэж үзэж болох материалыг нийтлэх, тараах гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг зохицуулна;
- 2023 онд батлагдсан **Цахим аюулгүй байдлын тухай хуулиар** цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах, хэрэглэгчдэд учирч буй хор хөнөөлийг зохицуулдаг. Энэ хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг удирдан чиглүүлэх Харилцаа холбооны алба (Office of Communications буюу Ofcom)-тай байна.

Мэдээлэл авах эрхийг тус улсын **Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар**[49] зохицуулдаг бөгөөд уг хуулийн үндсэн зарчим бол аливаа хүн төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар хүндэтгэх шалтгаангүй бол мэдэх эрхтэй. Төрийн байгууллагуудын эзэмшиж буй мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй болгох боломжийг дараах хоёр аргаар олгодог:

- төрийн эрх баригчид үйл ажиллагааныхаа талаар тодорхой мэдээллийг нийтлэх үүрэгтэй;

[48] ИБУИНХУ-ын Хүний эрхийн тухай хууль. https://www.legislation.gov.uk/ukpga/1998/42/schedule/1
[49] Freedom of Information Act 2000. https://ico.org.uk/for-organisations/foi/what-is-the-foi-act-and-are-we-covered/#:~:text=The%20Freedom%20of%20Information%20Act,request%20information%20from%20public%20authorities.

- олон нийтийн гишүүд төрийн байгууллагаас мэдээлэл хүсэх эрхтэй.

Уг хуулийн үйлчлэх хүрээ нь Англи, Уэльс, Умард Ирланд, мөн Шотландад төвтэй ИБУИНХУ-ын төрийн байгууллагуудын эзэмшиж буй бүх бүртгэгдсэн мэдээллийг хамарна. Шотландын төрийн байгууллагууд эзэмшиж буй мэдээлэл нь 2002 онд батлагдсан Шотландын өөрийнх нь Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар зохицуулдаг.

ИБУИНХУ-ын Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн дагуу төрийн байгууллагуудад Засгийн газрын байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, Үндэсний эрүүл мэндийн албан, улсын сургуулиуд, цагдаагийн байгууллага ордог. Гэхдээ энэ хуульд төсвийн мөнгө авдаг байгууллага бүрийг хамруулах албагүй. Тухайлбал, буцалтгүй тусламж авдаг зарим буяны байгууллага, төрийн чиг үүргийг гүйцэтгэдэг зарим хувийн хэвшлийн байгууллагуудад энэ хуулийн үйлчлэлд хамаарахгүй.

2.3.2.Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн үйл ажиллагаа, хариуцлагын талаарх эрх зүйн зохицуулалт

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн дагуу Харилцаа холбооны алба нь бүх арилжааны радио, телевизийн үйлчилгээнд лиценз олгодог. Лиценз нь өргөн нэвтрүүлэгчид дагаж мөрдөх нөхцөлүүдийг агуулдаг ба хэрэв эдгээр нөхцөл хангагдаагүй бол Харилцаа холбооны алба тухайн лицензийг хүчингүй болгох эрхтэй.[50]

Мөн Харилцаа холбооны алба нь тусгай зөвшөөрөл авсан радио, телевизийн сувгуудаар цацагдаж буй нэвтрүүлгүүдийн талаар сонсогч, үзэгчдээс ирүүлсэн гомдлыг шийдвэрлэх, шийдвэрлэх журмыг тогтоох үүрэгтэй. Ирүүлсэн гомдлыг дараах байдлаар шийдвэрлэнэ:

- анхны үнэлгээ: тухайн нэвтрүүлэг, контентыг хянан үзээд Өргөн нэвтрүүлгийн кодыг зөрчсөн эсэхийг тогтоох үнэлгээ хийх ба үнэлгээг 15 хоногийн дотор гүйцэтгэнэ;
- мөрдөн шалгах ажиллагаа: Өргөн нэвтрүүлгийн кодыг зөрчсөн нь тогтоогдсон бол тухайн нэвтрүүлэгчтэй холбоотой хэргийг бүлэглэх ба энэ ажиллагааг ажлын 50 хоногийн дотор гүйцэтгэнэ;
- хориг арга хэмжээ: уг арга хэмжээнд залруулга мэдэгдлийг цацах чиглэл өгөх, мөнгөн торгууль ногдуулах, тусгай зөвшөөрлийн хугацааг богиносгох, түдгэлзүүлэх болон хүчингүй болгох зэрэг орно.[51]

Тус алба нь Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хуулийн хүрээнд Өргөн нэвтрүүлгийн кодыг (Broadcasting Code) боловсруулах ба түүнд хяналт тавина. Өргөн нэвтрүүлгийн код нь 10 хэсгээс бүрдэх бөгөөд 5 болон 8 дугаар зарчим нь сэтгүүлчид хамааралтай хэсгийг дараах байдлаар түүвэрлэн оруулав.

5 дугаар зарчим. Мэдээллийг үнэн зөв мэдээлэх, шударга байдлыг хангах:

- 5.1.Мэдээллийг ямар ч хэлбэрээр үнэн зөвөөр тайлагнаж, шударгаар түгээх;
- 5.7.Үзэл бодол, баримт бичгийг гуйвуулж болохгүй;
- 5.11.Улс төрийн маргаантай асуудлууд болон төрийн бодлоготой холбоотой асуудлуудад шударга ёсыг баримтлах.[52]

8 дугаар зарчим. Хувийн нууцыг хамгаалах:

- 8.4.Нэвтрүүлэгчид олон нийтийн газар авсан бичлэг, зураг нь хувийн шинж чанартай бол холбогдох хувь хүн, байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай.
- 8.8.Албан байгууллагад зураг авалт, бичлэг хийхдээ холбогдох байгууллага, удирдлагаас зөвшөөрөл авна.

[50] https://lordslibrary.parliament.uk/regulation-of-news-broadcasting-companies/#heading-1
[51] https://lordslibrary.parliament.uk/regulation-of-news-broadcasting-companies/#heading-1
[52] https://www.ofcom.org.uk/tv-radio-and-on-demand/broadcast-standards/section-five-due-impartiality-accuracy/

- 8.14.Далд байдлаар зураг авалт, бичлэг хийх замаар олж авсан материалыг зөвхөн баталгаатай үед л цацна.
- 8.17.Хүнд нөхцөлд байгаа хүмүүсийг ямар ч үндэслэлгүйгээр нэвтрүүлэгт оролцох, ярилцлага өгөхийг шаардаж болохгүй.
- 8.18.Нэвтрүүлэгчид осол, хүчирхийллийн гэмт хэргийн улмаас нас барсан болон хохирогчийн хэн болохыг ойр дотнын хүмүүст нь мэдээлсэн эсэх нь тодорхой болтол, олон нийтэд мэдэгдэхгүй байх. Мөн түргэн тусламж, эмнэлэг, сургууль, хорих анги, цагдаагийн газар гэх мэт газруудад зураг авалт, бичлэг хийхээс өмнө зөвшөөрөл авах ёстой.
- 8.22.16-аас доош насны болон эмзэг бүлгийн хүмүүсийг эцэг, эх, асран хамгаалагч, эцэг эхийн 18 ба түүнээс дээш насны бусад хүн, эсхүл хариуцлага хүлээсэн хүний зөвшөөрөлгүйгээр хувийн асуудлаар байцааж болохгүй.

Тус улсад сэтгүүл зүйн салбарын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 1936 онд батлагдсан **Ёс зүйн дүрэмд** дүрэмд сэтгүүлзүйн гол зарчмуудыг нарийвчлан тусгасан байдаг[53]:

- хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх замаар олон нийтийн мэдээлэл авах эрхийг хангах;
- олон нийтэд үнэн зөв мэдээлэл хүргэхийг эрмэлздэг байх;
- алдаа гаргасан тохиолдолд залруулах;
- бодит баримт болон үзэл бодлыг ялгадаг байх;
- бусдын хувийн амьдралын асуудалд хөндлөнгөөс оролцохгүй байх;
- материал цуглуулахад ашигласан эх сурвалжийг хамгаалах;
- аливаа мэдээллийг олон нийтэд мэдэгдэхээс өмнө хувийн ашиг сонирхолд ашиглахгүй байх;
- хүний нас, хүйс, арьсны өнгө, шашин шүтлэг, эрх зүйн байдал, хөгжлийн бэрхшээл, гэр бүлийн байдал, бэлгийн чиг баримжаагаар нь ялгаварлан гадуурхахад хүргэх мэдээлэл түгээхгүй байх;
- өөрийн болон холбооны гишүүний ажиллаж буй хэвлэл мэдээллийн хэрэгслээс бусад аливаа бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлахгүй байх;
- насанд хүрээгүй хүүхдээс ярилцлага авах, зураг, бичлэг хийхдээ асран хамгаалах хүнээс нь зөвшөөрөл авах;
- оюуны өмчийн, бүтээлийн хулгай хийхгүй байх.

- Эх сурвалжаа хамгаалах талаар[54]:

  Сэтгүүл зүйн эх сурвалжийг хамгаалах нь хэвлэлийн эрх чөлөөний үндсэн нөхцөлийн нэг бөгөөд Үндэсний сэтгүүлчдийн нэгдсэн холбооны Ёс зүйн дүрэмд зааснаар сэтгүүлч нь “ажлынхаа явцад цуглуулсан нууц мэдээлэл, материалыг өгсөн эх сурвалжийн нэр төрийг хамгаална” гэж заасан байдаг. Энэ нь бүх салбарт ажилладаг сэтгүүлчдийн ажилд чухал ач холбогдолтой хэвээр байна.

  Гэвч Англи, Уэльст сэтгүүлчийн материалыг Цагдаа ба эрүүгийн нотлох баримтын тухай хууль (PACE)-ийн дагуу цагдаа нар хураан авахаас хамгаалдаг. Бодит байдал дээр цагдаа нар шүүгчээр уг асуудлыг шийдвэрлүүлдэг. Хэдийгээр Цагдаа ба эрүүгийн нотлох баримтын тухай хууль нь Шотландад үйлчилдэггүй ч цагдаа нар сэтгүүл зүйн материалд нэвтрэх зөвшөөрөл хүсдэг ажээ.

  1980, 90-ээд онд сэтгүүлч Билл Гүүдвин эх сурвалжийг хамгаалах асуудлаар Страсбург дахь Европын хүний эрхийн шүүхэд хандаж байсан. Шүүх түүний талд шийдвэр гаргаж, сэтгүүлчид үнэхээр эх сурвалжаа хамгаалж чадна, хамгаалах бүрэн эрхтэй гэж үзэв.

[53] https://www.nuj.org.uk/about-us/rules-and-guidance/ethics.html
[54] Police and Criminal Evidence Act, PACE. https://www.nuj.org.uk/resource/protection-of-sources.html

Шүүхийн шийдвэрт: “Сэтгүүл зүйн эх сурвалжийг хамгаалах нь хэвлэлийн эрх чөлөөний үндсэн нөхцөл мөн... ийм хамгаалалтгүй бол эх сурвалж нь олон нийтийн ашиг сонирхлын асуудлаар олон нийтэд мэдээлэл өгөхөд хэвлэлд туслахаас сэргийлж болно. Үүний үр дүнд хэвлэл мэдээллийн олон нийтийн манлайлагч байх амин чухал үүрэг алдагдаж, хэвлэл мэдээллийн үнэн зөв, найдвартай мэдээлэл өгөх чадвар муудаж болзошгүй” хэмээжээ.

2023 онд батлагдсан **Цахим аюулгүй байдлын тухай хууль** нь хэрэглэгчийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, цахим орчинд бус контентоос хамгаалах зорилготой.

- Худал мэдээлэл тараах талаар[55]:

ИБУИНХУ-ын Засгийн газар худал мэдээллийг тодорхойлохдоо “...улс төр, хувийн болон санхүүгийн ашиг сонирхлын үүднээс хүмүүсийг хууран мэхлэх, төөрөгдүүлэх зорилготой хуурамч мэдээллийг зориудаар бий болгож тараах” хэмээн тодорхойлсон байна.

Худал мэдээлэл тараахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2019 онд Дижитал, соёл, хэвлэл мэдээлэл, спортын газрын харьяанд Хуурамч мэдээллийн эсрэг алба байгуулсан бөгөөд уг алба нь олон нийтийн аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй худал мэдээлэлтэй холбоотой асуудлыг зохицуулах зорилготой.

Хуурамч мэдээллийн эсрэг алба нь Засгийн газар болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажилладаг. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр худал мэдээлэл тархсан тохиолдолд олон нийтэд үнэн зөв мэдээллийг түгээх, худал мэдээлэл тараахтай холбоотой олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх кампанит ажил явуулах, сошиал медиа компаниудтай хамтрах зэрэг үйл ажиллагаа явуулдаг байна.

Мөн ИБУИНХУ-д худал мэдээлэл тараах, гүтгэхтэй холбоотой асуудлыг дараах хуулиудаар зохицуулдаг:

- Цахим аюулгүй байдлын тухай хууль;
- Харилцаа холбооны тухай хууль;
- Гүтгэлгийн тухай хууль;
- Ёс суртахууны эсрэг харилцааны тухай хууль.

Мөн Цахим аюулгүй байдлын тухай хуулиар хэрэглэгчдийг цахим орчинд хамгаалах, тэдний аюулгүй байдлыг нэмэгдүүлэхийн тулд онлайн аюулгүй байдлын зохицуулагч Харилцаа холбооны алба нь цахим аналитикийг ашиглан худал мэдээлэл тараадаг цахим хуудаснуудыг ангилах, тэдгээрийг үүргээ биелүүлээгүй тохиолдолд 18 сая фунт стерлингээр торгох эрхтэй.

Гүтгэлгийн тухай хуулиар сэтгүүл зүй дэх гүтгэлэгтэй холбоотой харилцааг давхар зохицуулдаг.

- Гүтгэх хэргийн талаар[56]:

Сэтгүүлчид мэдүүлгийнхээ үнэн зөвийг нотлох шаардлагыг тэнцвэржүүлэхийн зэрэгцээ субъектийнхээ хувийн нууц, аюулгүй байдлыг хангах эрхийг тэнцвэржүүлэх ёстой. Нийтийн ашиг сонирхолд нийцсэн, олон нийт мэдэх эрхтэй мэдээллийг хуваалцахад сэтгүүл зүй чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүнд авлига, залилан мэхлэлт, бэлгийн хүчирхийлэл, улс төрийн хөндлөнгийн оролцоо, нэр хүндтэй олон нийтийн зүтгэлтнүүд болон эрх мэдэл, нөлөө бүхий хүмүүсийн талаарх мэдээ зэрэг багтана.

Гүтгэлгийн шинжтэй мэдэгдлийг нийтлэх, тараахад оролцсон аливаа хүн, аж ахуйн нэгж, ялангуяа зохиогч, редактор, нийтлэгч, сэтгүүлчдийг шүүхэд өгч болно. Тэдний хийсэн зүйл нь гүтгэлгийн шинжтэй мэдэгдэл гаргахад нөлөөлсөн, бөгөөд итгэх үндэслэлгүй байсан тохиолдолд Гүтгэлгийн тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

[55] https://commonslibrary.parliament.uk/research-briefings/cdp-2024-0003/
[56] https://www.legislation.gov.uk/ukpga/2013/26

2.3.3.Хэвлэн нийтлэх эрх чөлөө, сэтгүүлчийн эрхийг хамгаалах субъект

1907 онд байгуулагдсан **Үндэсний сэтгүүлчдийн нэгдсэн холбоо** нь 30,000 гаруй гишүүнтэй дэлхийн хамгийн том сэтгүүлчдийн эвлэлүүдийн нэг бөгөөд мэдээллийн агентлаг, ном, сонин, сэтгүүл, олон нийттэй харилцах, харилцаа холбоо, гэрэл зураг, хэвлэл мэдээллийн салбарт ажилладаг хүмүүс нэгдэн ажилладаг байна.[57] Тус холбоо нь хэвлэл мэдээллийн салбарт үйл ажиллагаа явуулдаг хүмүүсийн ажиллах нөхцөл байдлыг сайжруулах үндсэн зорилготой.

Сэтгүүл зүйн салбар нь хүчирхийлэл, айлган сүрдүүлэлт, заналхийлэлтэй тулгарах магадлал маш өндөр байдаг бөгөөд эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд **Сэтгүүлчдийн аюулгүй байдлын үндэсний хороог**[58] 2020 онд байгуулсан. Уг хороо нь сэтгүүл зүйгээс гадна Засгийн газар, цагдаа, прокурорын алба, иргэний нийгмийн төлөөллийг нэгтгэн хамтран ажилладаг.

Хорооны гишүүдийн бүрэлдэхүүнд дор дурдсан хүмүүс ордог[59]:

- Дижитал, соёл, хэвлэл мэдээлэл, спортын газрын дарга, Дотоод хэргийн сайд нар хамтран даргалах бөгөөд нарийн бичгийн дарга нар нь дэмжин ажиллана;
- цагдаа, прокурор, сэтгүүл зүйн байгууллагын удирдах ажилтнууд ажиллана;
- сэтгүүлчдийг урьж, туршлага хуваалцах байдлаар хамтарч ажиллана;
- төрийн бусад байгууллагын төлөөлөгчдийг ажиглагчаар ажиллуулж болно.

Тус хороо нь жилд 2 удаа хуралдах ба ИБУИНХУ-д сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах үйл ажиллагааны “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах үндэсний төлөвлөгөө” (National Action Plan for the Safety of Journalists)-г боловсруулж, нийтлэх, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг.

Энэхүү төлөвлөгөөний зорилго нь тус улсад үйл ажиллагаа явуулж буй сэтгүүлчдийг аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, тэдэнд чиглэсэн халдлага, заналхийллийг бууруулах, буруутай этгээдийг хуулийн өмнө хариуцлага хүлээлгэх үндсэн зорилготой. Энэхүү зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах чиглэлээр чиг үүргүүдийг хэрэгжүүлнэ[60]:

1) Сэтгүүлчдэд учирч буй аюул, хүчирхийллийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх –

- Дотоод хэргийн яамнаас сэтгүүлчдэд тулгамдаж буй заналхийлэл, хүчирхийллийн хэмжээ, төрөл зэргийг тодорхойлох, тухайн асуудлыг шийдвэрлэх арга замыг бий болгох;
- сэтгүүлчдийн асуудлыг тодорхойлох судалгааг жил бүр хийх;
- бусад улс орны сайн туршлагыг хуваалцахад туслах.

2) Сэтгүүлчдийн эсрэг гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх арга хэмжээг бэхжүүлэх –

Сэтгүүлчдэд учруулсан хохирол нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй байсан тохиолдолд буруутай этгээдийг хуулийн өмнө хариуцлага хүлээлгэхийн тулд ажиллана. Буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхийн тулд сэтгүүлч юу мэдээлэх боломжтой, юуг мэдээлэх ёстой талаар ойлголтой байх, хангалттай нотлох баримт цуглуулсан байх зэрэг олон асуудлыг хамарна. Дараах арга хэмжээг авч ажиллана:

- цагдаагийн байгууллага нь Сэтгүүлчдийг сургах үндэсний зөвлөлтэй хамтран сэтгүүлчдэд цагдаагийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх сургалт явуулах;
- цагдаагийн алба бүр сэтгүүлчийн аюулгүй байдлыг хариуцсан ажилтантай байх;
- цагдаа нарт сэтгүүлчдийн эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгахтай холбоотой сургалтыг Үндэсний сэтгүүлчдийн холбоо, Редакторуудын нийгэмлэг болон бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

[57]https://www.tuc.org.uk/unions/nuj#:~:text=The%20National%20Union%20of%20Journalists,freelances%20at%20home%20and%20abroad
[58] National Committee for the Safety of Journalist. https://www.gov.uk/government/groups/national-committee-for-the-safety-of-journalistsc
[59] https://assets.publishing.service.gov.uk/media/5f3bdcc68fa8f517468a05a1/Terms_of_Reference_-_National_Committee.pdf
[60] https://www.gov.uk/government/news/new-plans-to-promote-media-freedom-and-protect-journalists

- Үндэсний цагдаагийн дарга нарын зөвлөл нь сэтгүүлчдийн эсрэг гэмт хэрэгт хариуцлага хүлээх удирдлагыг тодорхойлно.

3) Сэтгүүлчид болон тэдний ажил олгогчдыг хувийн аюулгүй байдлыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх –

- Хэвлэл мэдээллийн хуульчдын холбоо (Media Lawyers Association) нь сэтгүүлчдэд хууль бус байж болзошгүй аюулгүй байдлыг нь алдагдуулах хүчирхийллийг танихад туслах;
- Үндэсний сэтгүүлчдийн холбоо, Редакторуудын нийгэмлэг[61] нь ИБУИНХУ-ын цагдаагийн төлөөлөгчид болон Сэтгүүлч бэлтгэх үндэсний зөвлөлтэй[62] хамтран ажиллах;
- Үндэсний сэтгүүлчдийн холбоо, Редакторуудын нийгэмлэг аливаа аюул заналхийлэл тохиолдсон сэтгүүлчдэд зориулсан яаралтай тусламжийн сан[63] байгуулах;
- Сэтгүүлч бэлтгэх үндэсний зөвлөл нь аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулах.

4) Цахим орчинд болж буй хүчирхийллийг шийдвэрлэх –

Цахим хүчирхийлэл нь сэтгүүлчдэд тулгарч буй аюулгүй байдлын хамгийн чухал сорилтуудын нэг бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд Засгийн газраас Цахим аюулгүй байдлын тухай хуулийн төсөл боловсруулан Парламентаар батлуулжээ. Засгийн газрын үзэж байгаагаар энэ хууль батлагдсанаар зөвхөн сэтгүүлчдэд зориулсан бус цахим сүлжээ ашиглаж буй бүх хүмүүсийн цахим орчны аюулгүй байдал хангагдах аж. Тухайлбал, цахим орчинд сэтгүүлчдийн аюулгүй байдалд халдсан тухай мэдээлэлд яаралтай хариу арга хэмжээ авах эрх зүйн үндсийг тусгасан байна.

5) Сэтгүүлчдийн нийгэмд үзүүлэх үнэ цэнийг олон нийтэд таниулахад туслах –

- Засгийн газар цахим сүлжээг зохистой ашиглах стратегийг (Online Media Literacy Strategy) боловсруулах замаар сэтгүүлчдийн үүрэг тэдний нийгэмд үзүүлэх үнэ цэний тухай олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх;
- Засгийн газраас хэрэгжүүлж буй “Сэтгүүл зүйн асуудал” компанит ажлаар дамжуулан сэтгүүлчдийн аюулгүй байдлын тухай онцлон харуулах.

Хэвлэл мэдээллийн хуульчдын холбоо[64] нь ИБУИНХУ-ын хэвлэл мэдээллийн хэрэгслийн хуульчдын холбоо бөгөөд гишүүд нь тус улсын томоохон хэвлэн нийтлэгчид, нэвтрүүлэгчид, олон улсын мэдээллийн байгууллагуудын хуульчид багтдаг. Тус холбооны зорилго нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хүн бүр үнэн зөв мэдээлэл хүлээн авах эрхийг дэмжих, хамгаалахад оршино.

“Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах үндэсний төлөвлөгөө”-ний дагуу тус холбоо болон Дижитал, соёл, хэвлэл мэдээлэл, спортын газар хамтран сэтгүүлчдэд зориулсан эрх зүйн гарын авлага бэлтгэн гаргадаг. Энэхүү гарын авлага нь сэтгүүлчдийн аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх, цахим орчин дахь хүчирхийллээс хамгаалах зөвлөгөө, заавар өгөх зорилготой.[65]

Сүүлийн жилүүдэд хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд учирч буй нэг асуудал нь **“Олон нийтийн оролцооны эсрэг стратегийн заргa”** (Slapps) юм. Энэ нь нийтийн эрх ашгийн төлөө дуугарсан хүмүүсийг айлган сүрдүүлж, эцэст нь дуугүй болгоход ашигладаг хууль ёсны дарамтын нэг хэлбэр юм.

“Сэтгүүлчдийн аюулгүй байдлын Үндэсний хорооны төлөвлөгөө”-ний хүрээнд Дижитал, соёл, хэвлэл мэдээлэл, спортын газар болон Хууль зүйн яамтай хамтран уг стратегийн заргаас учрах эрсдэлийг бууруулахын тулд ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг нь төрийн болон

[61] https://www.societyofeditors.org/about/
[62] https://www.nctj.com/about-nctj/
[63] https://www.nuj.org.uk/resource/ifj-safety-funds.html
[64] Media Lawyers Association. https://medialawyersassociation.org/members/
[65] https://medialawyersassociation.org/wp-content/uploads/2021/06/combatting-online-harassment-and-abuse-23.06.2021-09.10-5.pdf

иргэний нийгэм, сэтгүүлчдийн төлөөллийн байгууллага, оролцогч талуудыг нэгтгэн уг стратегийн заргын эсрэг хууль тогтоомжийн бус хариу арга хэмжээг боловсруулах зорилготой юм.

2.4.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

2.4.1.Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийн талаарх эрх зүйн зохицуулалт

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-д үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхтэй холбоотой харилцааг дараах хуулиудаар зохицуулдаг:

- Үндсэн хууль;
- Берлиний Хэвлэлийн тухай хууль[66];
- Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль[67];
- бусад хууль тогтоомж болон муж улсуудын хэвлэл мэдээллийн тухай хуулиуд.

Тус улсын **Үндсэн хуулийн** 5 дугаар зүйлд “Хүн бүр өөрийн үзэл бодлоо үгээр, бичгээр, дүрсээр чөлөөтэй илэрхийлэх, түгээх болон олон нийтэд нээлттэй эх сурвалжаас мэдээллийг саадгүй авах эрхтэй. Хэвлэлийн эрх чөлөө болон өргөн нэвтрүүлэг ба дүрс бичлэгээр мэдээлэл түгээх эрх чөлөөний баталгааг төр хангана. Аливаа цензур тогтоохыг хориглоно.” гэж заасан.

Үндсэн хуулийн 18 дугаар зүйлд “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ялангуяа хэвлэлийн эрх чөлөө (5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг), сургалтын эрх чөлөө (5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг), цуглаан хийх эрх чөлөө (8 дугаар зүйл), эвлэлдэн нэгдэх эрх чөлөө (9 дүгээр зүйл), захидал, шуудан харилцаа холбооны нууцын эрх (10 дугаар зүйл), өмчлөх эрх (14 дүгээр зүйл), эсхүл орогнох эрхээ (16а дугаар зүйл) чөлөөт ардчилсан үндсэн дэг журмын эсрэг урвуулан ашигласан этгээд эдгээр үндсэн эрхээ алдана. Үндсэн эрх алдагдах тухай болон түүний хэр хэмжээний тухай асуудлыг Холбооны улсын Үндсэн хуулийн шүүх шийдвэрлэнэ.” хэмээн заасан байдаг.

1965 онд батлагдсан **Берлиний Хэвлэлийн тухай хуульд** хэвлэл мэдээлэлтэй холбоотой дараах зохицуулалтыг тусгасан байдаг:

1) хэвлэлийн эрх чөлөө;
2) хэвлэл мэдээллийн байгууллага байгуулах эрх чөлөө;
3) хэвлэлийн үүрэг;
4) хэвлэлийн мэдээлэл авах эрх;
5) өмчлөх, хувьцаа эзэмших харилцааг ил болгох тухай;
6) хариуцлагатай редакторуудад тавигдах шаардлага;
7) төлбөртэй мэдээллийн тодорхойлолт;
8) мэдэгдэл гаргах эрх (gegendarstellungsanspruch);
9) хориглосон хэвлэмэл бүтээлийг олон нийтэд тараахыг хориглох зэрэг болно.

Мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд тус холбооны улсын төрийн байгууллагуудаас албан ёсны мэдээллийг шууд авах эрхийг хуульчилсан. Энэ хуульд зааснаар “албан ёсны мэдээлэл” гэдэгт хэрхэн хадгалагдаж байгаагаас үл хамааран албан ёсны бүх мэдээлэл ордог.

Энэ хуулийн дагуу холбооны улсын төрийн байгууллагууд нь хувийн мэдээллээс бусад буюу байгууллагын зохион байгуулалт, төлөвлөгөө гэх мэт мэдээллийг олон нийтэд нээлттэй байршуулах үүрэг хүлээсэн.

Мөн холбооны улсын төрийн байгууллагууд нь мэдээллийг амаар, бичгээр, эсхүл цахим хэлбэрээр өгч болно. Мэдээлэл өгөхдөө төрийн үйлчилгээнд хамаарах төлбөр, үйл ажиллагааны зардлыг энэ хуулийн дагуу тооцдог ба үүнд энгийн мэдээлэл хамаарахгүй.

[66] Berliner Pressegesetz. www.medienstrafrecht.de/landespressegesetz/berliner-pressegesetz-blnprg/
[67] Informationsfreiheitsgezetz www.gesetze-im-internet.de/ifg/__1.html

Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар гуравдагч этгээд хөндлөнгөөс оролцох журмыг зохицуулснаараа онцлогтой юм. Тодруулбал, мэдээлэл авах хүсэлтийн дагуу эрх ашиг нь хөндөгдөж буй гуравдагч этгээдэд мэдээлэлд нэвтрэх эрхийг хориглосон тохиолдолд нэг сарын дотор бичгээр тайлбар өгөх боломжийг тухайн холбооны төрийн байгууллага олгожээ.

Мөн энэ хуулийн дагуу Холбооны улсын мэдээллийн чөлөөт байдлыг хариуцсан ажилтан байх бөгөөд мэдээлэл авах эрх нь зөрчигдсөн хүн бүр тус ажилтанд хандаж болох аж.

Мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд дараах хамгаалалтын зохицуулалтыг тусгасан:

- нийтийн тусгай ашиг сонирхлыг хамгаалах талаар: нийтэд сөрөг үр дагавар гарч болзошгүй мэдээллийг нийтэд мэдээлэхгүй;
- шийдвэр гаргах үйл явцыг хамгаалах талаар: шийдвэр гаргахаас өмнө олон нийтэд энэ талаар мэдээлэхдээ тухайн шийдвэрт нөлөөлөхүйц мэдээллийг нээлттэй өгөхгүй;
- хувь хүний мэдээллийг хамгаалах талаар: мэдээлэл авах өргөдөл гаргасан этгээдэд мэдээлэл авах эрх нь хасагдсан, эсхүл гуравдагч этгээдийн зөвшөөрлөөр тухайн хүний овог нэр, албан тушаал, эрдмийн цол зэрэг, холбогдох утас, ажлын газрын хаяг зэрэг мэдээллийг авч болно;
- оюуны өмч, байгууллагын үйл, бизнесийн нууцтай холбоотой мэдээллийг хамгаалах талаар: энэ нь оюуны өмчийг хамгаалахтай зөрчилдвөл мэдээлэл авахгүй. компанийн болон бизнесийн нууцад нэвтрэх эрхийг зөвхөн холбогдох этгээд зөвшөөрсөн тохиолдолд мэдээллээр хангана.

ХБНГУ-ын муж улс болгон хэвлэл мэдээллийн хуультай бөгөөд эдгээр хуулиудад эрүүгийн болон захиргааны зөрчлийн заалтууд байдаг.

2.4.2.Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн үйл ажиллагаа, хариуцлагын талаарх эрх зүйн зохицуулалт

Сэтгүүлчдийн холбооноос **Сэтгүүлчийн ёс зүйн дүрмийг** 1973 онд баталсан. Тус дүрмийн 1 дүгээр хэсэгт зааснаар “Үнэнийг дээдлэх, хүний нэр төрийг сахин хамгаалах, олон нийтэд үнэн зөв мэдээлэл өгөх нь хэвлэлийн гол зарчим юм. Тиймээс хэвлэлд ажиллаж байгаа хүн бүр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх эрх мэдэл, итгэлийг хадгалж байдаг.” гэж заасан байна.

Энэхүү дүрмийн дагуу мэргэжлийн ёс зүй зөрчсөн тохиолдолд гомдол гаргах үндэслэлийг тогтоосон байна.

Сэтгүүлчийн ёс зүйн дүрэм нь нийт 16 зүйлтэй:

1) Үнэнийг дээдлэх, хүний нэр төрийг хамгаалах;
2) Хянуур байх;
3) Залруулга хийх;
4) Судалгааны хязгаарлалт;
5) Мэргэжлийн нууцлал;
6) Бусад үйл ажиллагаанд оролцохоос зайлсхийх;
7) Редакцын агуулгыг алдагдуулахгүй зар сурталчилгааг тусгаарлах;
8) Хувь хүний мэдээллийг хамгаалах;
9) Хүний нэр төрийг хамгаалах;
10) Шашин, философи, ёс зан заншлыг хүндэтгэх;
11) Хүчирхийлэл, харгислалын талаарх зохисгүй мэдээ, мэдээллийг сурвалжлахаас зайлсхийх, залуучуудыг хамгаалах;
12) Ялгаварлан гадуурхах;
13) Гэм буруугүйн талаарх мэдээлэл;
14) Хувь хүний эрүүл мэндийн талаар мэдээлэх;
15) Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
16) Иргэдээс ирүүлсэн шүүмжлэлийг хэвлэн нийтлэх зохицуулалтыг оруулсан байна.

Сэтгүүлчид мэдээллийн эх сурвалжаа зарлахаас татгалзах эрхийг ХБНГУ-ын Эрүүгийн болон Иргэний процессын хуулиар зохицуулдаг. **Эрүүгийн процессын тухай хуулийн** 53 дугаар зүйлд радиогийн болон хэвлэлийн сэтгүүлчдэд итгэл хүлээсэн мэдээллийн эх сурвалж, агуулгатай холбоотой нотолгоо өгөхөөс татгалзах эрхийг олгожээ. **Иргэний процессын хуулийн** 383 дугаар зүйлд "Сэтгүүлч мэргэжлээсээ шалтгаалан хүмүүст итгэмжлэгдсэн фактууд байгаа бол илчлэх талаарх эх сурвалжийн зөвшөөрөлгүйгээр тэдгээр фактын талаар мэдүүлэг, нотолгоо өгөхөөс татгалзах эрхтэй." хэмээн хуульчилжээ.[68]

Берлиний Хэвлэлийн тухай хуулиар үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг зөрчсөн тохиолдолд эрүүгийн, захиргааны хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан.

- Эрүүгийн хариуцлага тооцох талаар (19 дүгээр зүйл):

  Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсан мэдээлэл нь гэмт хэргийн шинжтэй бол өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр гэмт хэргийн агуулга бүхий мэдээ, мэдээлэл түгээхгүй байх, мэдээлэлд хяналт тавих үүргээ биелүүлээгүй хариуцлагатай редакторт 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, эсхүл мөнгөн торгууль оногдуулна.

- Захиргааны хариуцлага тооцох талаар (21 дүгээр зүйл):

  Санаатай, эсхүл болгоомжгүйгээс болж захиргааны хэргийн дараах зөрчил гаргасан этгээдэд 5,000 хүртэлх еврогийн торгууль оногдуулна:

  - хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлага, хариуцлагатай редактор энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан хэвлэлийн дардас дутуу хэвлэмэл бүтээлийг хэвлэж, түгээсэн бол;
  - энэ хуулийн 7а дугаар зүйлд заасан тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшигч болон хувьцаа эзэмшигчдийн ил тод байдлыг зөрчсөн бол;
  - хариуцлагатай редактор, эсхүл эрх бүхий албан тушаалтан нь төлбөртэй мэдээллийг хэвлэн нийтлэхдээ "төлбөртэй мэдээлэл" гэсэн тэмдэглэгээ тавиагүй бол.

- Хэвлэлийн журам зөрчсөн гэмт хэрэгт хариуцлага тооцох талаар (20 дугаар зүйл):

  Доор дурдсан гэмт хэргийг үйлдсэн этгээдэд 5 сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл 180 хоногийн хөдөлмөрийн хөлстэй тэнцэх хэмжээний мөнгөн торгууль оногдуулна:

  - хэвлэл мэдээллийн байгууллага нь энэ хуулийн 8 дугаар зүйл хариуцлагатай редакторт тавигдах шаардлагыг хангаагүй этгээдийг хариуцлагатай редактораар томилсон бол,
  - тавигдах шаардлагыг хангаагүй хариуцлагатай редактор нь мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээх зөвшөөрөл олгож гарын үсэг зурсан бол;
  - хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлага, хариуцлагатай редактор нь гэмт хэргийн агуулгатай мэдээ, мэдээллийг хэвлэн нийтэлж, дардастай холбоотой журмыг зөрчсөн бол;
  - энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан хураагдсан хэвлэмэл бүтээгдэхүүнийг түгээхийг хориглосон мэдээ, мэдээллийг хэвлэн нийтлэх, олон нийтэд түгээх, дахин хэвлэсэн бол.

Эрүүгийн хуулийн 14 дүгээр бүлэгт нэр төрийг гутаах, гүтгэх, худал мэдээлэл, доромжлох, худал цуу яриа тараах, нас барсан хүний дурсгалыг доромжлох зэрэгтэй холбоотой 11 гэмт хэргийг тусгасан байдаг. Тодруулбал, бусдыг гүтгэх (187), доромжлох (185), худал цуу яриа тараах (186), нас барсан хүний дурсгалыг доромжлох (189), шүүхийн шийдвэрээр үнэнийг нотлох (190), улс төрчтэй холбоотой худал цуу яриа болон гүтгэлэг (188), харилцан бие биеэ доромжлох (199), үнэн байдал нотлогдсоныг үл харгалзан доромжлох (192), эрүүгийн хэрэг үүсгэх өргөдөл, гомдол (194), хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах (193), шийтгэх тогтоол гаргах (200) зэрэг өргөн хүрээг хамарсан байдаг бөгөөд гүтгэх, доромжлох гэмт хэргийг тусад нь хуульчилсан.[69]

[68] М.Доржханд. Сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах тухай хуулийн харьцуулсан судалгааны тайлан. https://www.globeinter.org.mn/images/upld/12057323951199256477sudalgaanii%20tailan_2.pdf

[69] "Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик" судалгааны тайлан. ННФ. 2021 он.

- Худал мэдээлэл тараах, доромжлох, гүтгэх талаар:

  Доромжлох гэмт хэрэг үйлдсэн бол 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, эсхүл торгоно. Хүч хэрэглэх замаар доромжилсон бол 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ (185 дугаар зүйл);

  Бусдын нэр хүндийг унагаж, олон нийтийн өмнө гутаан доромжлуулахын тулд түүний талаар нотлогдоогүй баримт зарласан, эсхүл тараасан бол 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, эсхүл торгоно. Хэрэв бусдын нэр хүндийг хурал, цуглааны үеэр болон контентоор дамжуулсан бол 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, эсхүл торгоно.[70] (186 дугаар зүйл);

  Бусадтай холбоотой баримт худал гэдгийг мэдсээр байж олон нийтийн өмнө гутаан доромжлуулж, зээлийн чадварт нь эрсдэл учруулахын тулд түүний талаар худал баримт зарласан, тараасан бол 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ[71] (187 дугаар зүйл).

2.4.3.Хэвлэн нийтлэх эрх чөлөө, сэтгүүлчийн эрхийг хамгаалах субъект

Хэвлэлийн байгууллагууд, сэтгүүлчид, редакторууд нэгдэж 1956 онд байгуулсан **Германы хэвлэлийн зөвлөл**[72] нь тус улсын хэвлэл мэдээллийн салбарын зохицуулалтыг хангах үүрэгтэй ашгийн бус байгууллага бөгөөд сэтгүүлчдийн 2 холбоо, сонин, сэтгүүл хэвлэлийн 2 холбооноос бүрддэг:

- Германы цахим хэвлэл, сонин эрхлэн нийтлэгчдийн;
- Германы сэтгүүлчдийн холбоо;
- Худалдаа, үйлчилгээний нэгдсэн холбооны Германы сэтгүүлчдийн холбоо;
- Германы сэтгүүл нийтлэгчдийн холбоо.

Германы хэвлэлийн зөвлөлийн удирдах байгууллага болох Бүгд хурал нь 28 гишүүнтэй бөгөөд гишүүдийг тус зөвлөлийн гишүүн байгууллага тус бүрээс 7 гишүүнийг томилдог. Бүгд хурал нь гомдол шийдвэрлэх 3 хороотой (Ерөнхий хороо 2, Редакцын мэдээллийг хамгаалах хороо).

Тус зөвлөл нь хэвлэл мэдээллийн байгууллагын нэр хүнд, эрх чөлөөг хамгаалахын сацуу сэтгүүлчдийн мэдээллийн хүртээмж, мэдээллийг авах боломжоор хангах, редакцын мэдээллийг хамгаалах, ХБНГУ-ын Берлиний Хэвлэл мэдээллийн тухай хуулийн дагуу Сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлдэг. Мөн хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа, хэвлэл мэдээллээр нийтлэгдсэн бүх төрлийн мэдээ, мэдээлэлтэй (үүнд цахим орчинд нийтлэгдсэн мэдээ, мэдээлэл хамаарна) холбоотой гомдлыг хүлээн авч шийдвэрлэх бөгөөд дараах хариуцлагыг хүлээлгэх эрхтэй:

- сануулга өгөх (уг сануулгыг заавал хэвлэн нийтэлнэ);
- сануулга өгөх (хохирогчийг хамгаалах үүднээс хэвлэн нийтлэх шаардлагагүй);
- буруутгах мэдэгдэл өгөх;
- зөвлөх мэдэгдэл өгөх.

Үүнээс гадна буруутай үйлдэл хийсэн хэвлэл мэдээллийн байгууллага нь нийтэлсэн мэдээлэлдээ залруулга гаргах, редакцын засвар хийсэн тохиолдолд гомдол шийдвэрлэх хороо хариуцлага хүлээлгэхээс татгалзах эрхтэй байдаг.

[70] ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 186 дугаар зүйл, www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html#p1893
[71] Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик" судалгааны тайлан. ННФ. 2021 он.
[72] German Press Council. www.presserat.de/en.html

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- М.Доржханд. Сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах тухай хуулийн харьцуулсан судалгааны тайлан. https://www.globeinter.org.mn
- Б.Пүрэвсүрэн. Монгол Улс дахь хэвлэн нийтлэх эрх чөлөөний хэрэгжилт, тулгамдсан асуудал. https://legaldata.mn/b/693
- Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс. https://rsf.org/en/index
- Convention on the Political Rights of Women. https://treaties.un.org
- Convention on the Rights of the Child (CRC). www.ohchr.org
- Freedom and the Media 2019: A Downward Spiral. Freedom House. June 2019. https://freedomhouse.org
- Freedom and the Media 2019: A Downward Spiral. Freedom House. June 2019. https://freedomhouse.org
- International Covenant on Civil and Political Rights (ICCPR). www.ohchr.org
- Jonas Nordin. The Swedish Freedom of the Press Ordinance of 1766: Background and Significance. 2023.
- Universal Declaration of Human Rights (UDHR). www.ohchr.org
- https://ipi.media
- https://research.tuni.fi
- https://rsf.org
- https://upr-mongolia.mn
- www.ifj.org
- www.ohchr.org
- www.unesco.org

БНСУ

- БНСУ-ын Үндсэн хууль. https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=1
- БНСУ-ын Сонины тухай хууль. www.law.go.kr
- БНСУ-ын Өргөн нэвтрүүлгийн тухай хууль. www.law.go.kr
- https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=24492&lang=ENG
- www.law.go.kr
- БНСУ-ын Иргэний хууль. www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EB%AF%BC%EB%B2%95
- БНСУ-ын Эрүүгийн хууль. www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EB%B2%95
- www.journalist.or.kr/news/section4.html?p_num=4

БНЭУ

- Д.Баярхүү. Энэтхэг: Сонгуулийн соёл ба улс төрийн эрх мэдэл. Шинэ толь №23, 2000. https://academy.edu.mn
- Constitution of India. https://legislative.gov.in/constitution-of-india/
- Cable television networks (regulation) Act, 1995. www.indiacode.nic.in/handle/123456789/1928
- Committee to Protect Journalists. https://cpj.org/data/killed/asia/india/
- Information Technology Act, 2000. www.indiacode.nic.in/handle/123456789/1999
- Press and registration of periodicals act, 2023. www.indiacode.nic.in/handle/123456789/20162
- Press Council of India. www.presscouncil.nic.in/ResumeOfPCI.aspx
- Right to Information Act, 2006. www.indiacode.nic.in/bitstream/123456789/2065/5/a2005-22.pdf
- Telecom Regulatory Authority of India (TRAI). https://trai.gov.in
- Telecom Regulatory Authority of India Act, 1997. www.indiacode.nic.in/handle/123456789/1929
- Working Journalists and other Newspaper Employees (Conditions of Service) and Miscellaneous Provisions Act, 1955. www.indiacode.nic.in/handle/123456789/1504?view_type=browse
- Bharatiya Nyaya Sanhita, 2023. www.indiacode.nic.in/handle/123456789/20062?view_type=search&col=123456789/1362

- Indian Journalists' Union (IJU). https://iju.org.in
- National Union of Journalist India (NUJ-I). www.nujindia.com
- www.indiacode.nic.in
- https://byjus.com/free-ias-prep/freedom-of-speech/

ИБУИХУ

- ИБУИНХУ-ын Хүний эрхийн тухай хууль. https://www.legislation.gov.uk/ukpga/1998/42/schedule/1
- Freedom of Information Act 2000. https://ico.org.uk
- Media Lawyers Association. https://medialawyersassociation.org/members/
- National Committee for the Safety of Journalist. https://www.gov.uk/government/groups/national-committee-for-the-safety-of-journalistsc
- Police and Criminal Evidence Act, PACE. https://www.nuj.org.uk/resource/protection-of-sources.html
- https://assets.publishing.service.gov.uk/media/5f3bdcc68fa8f517468a05a1/Terms_of_Reference_-_National_Committee.pdf
- https://commonslibrary.parliament.uk/research-briefings/cdp-2024-0003/
- https://lordslibrary.parliament.uk/regulation-of-news-broadcasting-companies/#heading-1
- https://medialawyersassociation.org/wp-content/uploads/2021/06/combatting-online-harassment-and-abuse-23.06.2021-09.10-5.pdf
- https://www.gov.uk/government/news/new-plans-to-promote-media-freedom-and-protect-journalists
- https://www.legislation.gov.uk/ukpga/2013/26
- https://www.nctj.com
- https://www.ofcom.org.uk
- https://www.societyofeditors.org
- https://www.tuc.org.uk

ХБНГУ

- Reporters without borders https://rsf.org/en/country/germany
- Сэтгүүлчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн төсөл боловсруулах судалгаа, Конрад-Аденауэр Сангийн, 2021 он
- European centre for press & media freedom www.ecpmf.eu/engage/slapp/
- German Press Council, www.presserat.de/en.html
- www.medienstrafrecht.de/landespressegesetz/berliner-pressegesetz-blnprg/
- Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль. www.gesetze-im-internet.de/ifg/
- Берлиний хэвлэлийн тухай хууль. www.medienstrafrecht.de/landespressegesetz/berliner-pressegesetz-blnprg/
- Informationsfreiheitsgezetz www.gesetze-im-internet.de/ifg/__1.html
- “Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик” судалгааны тайлан. ННФ. 2021 он.
- ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 186 дугаар зүйл, www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html#p1893
- Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик” судалгааны тайлан. ННФ. 2021 он.
- German Press Council. www.presserat.de/en.html